



**USAID**  
FROM THE AMERICAN PEOPLE



*Yàèéí çàñàèéí áí àèí àúí øèí ýòàýè,  
òñ°èä°õ ÷ààààð ò°ñ°è*

# Монгол улсын татварын хөнгөлөлт үзүүлэх ажлыг дэмжих мэдээлэл харилцааны стратеги

2005 оны 4 дүгээр сар  
Улаанбаатар

Энэ баримт бичгийг Америкийн Нэгдсэн Улсын Олон улсын хөгжлийн агентлагаар хянуулахаар боловсруулав. Энэ баримт бичигт илэрхийлсэн үзэл бодол нь Америкийн Нэгдсэн Улсын Олон улсын хөгжлийн агентлаг эсвэл Америкийн Нэгдсэн Улсын Засгийн газрын үзэл бодлыг заавал тусгасан байх албагүй болно.



Төсөл: Эдийн засгийн бодлогын шинэтгэл, өрсөлдөх чадвар (ЭЗБШӨЧ)  
Тайлангийн нэр: *Монгол Улсын татварын хөнгөлөлтийн үйл явцыг дэмжих  
мэдээлэл харилцааны стратеги*

Тайлан бичсэн: Барбара Задина  
Гэрээний дугаар: 438-С-00-03-00021-00  
Байгууллага: ЭЗБШӨЧ Төсөл/Кемоникс Интернэйшнл Инк., Монгол Улс,  
Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, Ерөнхий сайд Амарын гудамж,  
Таван Богд Плаза

Утас, факс: (976) 11 32 13 75 Факс: (976) 11 32 78 25  
Холбоо барих хүн: Фернандо Бертоли, Төслийн удирдагч  
И-мэйл хаяг: [fbertoli@eprc-chemonics.biz](mailto:fbertoli@eprc-chemonics.biz)



## ТАЛАРХАЛ

---

Энэхүү тайланг бэлтгэхэд олон хүн үнэлж барамгүй туслалцаа үзүүлээ. Юуны өмнө надаас суралцуулах гэж “дагалдан” болгож явуулсан боловч оновчтой асуулт асууж, нөхцөл байдлын талаар шинэлэг санал дэвшүүлэн, үнэн хэрэгтээ надад их зүйлийг зааж өгсөн Кемоникс Интернэйшнл Инк.-ийн Азийн бүсийн ажилтан Жереми Шанкад талархлаа илэрхийлье. Мөн миний бие Азийн сангийн ажилтнууд болох Лейтон Крофт, М. Бадамдаш нартай хамтран энэхүү тайланг бэлтгэх үүрэг хүлээж ажилласан юм. Газар дээр нь ажилладаг мэдээлэл харилцааны мэргэжилтнүүдийн хувьд тэдний өгсөн чиглэл Монголын нөхцөл байдлыг ойлгож, хэрэгжүүлэх боломжтой, үр дүн өгөхүйц ажлын төлөвлөгөө боловсруулахад зайлшгүй хэрэгтэй байсан юм. Тэднийг энэхүү төлөвлөгөөг амжилттай хэрэгжүүлнэ гэж итгэж байна. ЭЗБШӨЧ Төслийн эдийн засгийн зөвлөх Януш Ширмерт татварын шинэчлэл хийхэд тохиолдох бэрхшээл, гарах үр нөлөөг ойлгуулахын тулд надад эдийн засгийн мэдлэг олгох эрчимжүүлсэн хичээлийг тэвчээр гарган зааж, коммунизмын дараахь шилжилтийн эдийн засгийн талаар хувийн санал бодлоо хуваалцаж байсанд гүнээ талархаж байна. Эцэст нь байнга дэмжлэг туслалцаа үзүүлж ЭЗБШӨЧ Төслийн гэр бүлд байгаа мэт сэтгэгдэл төрүүлж байсан Фернандо Бертоли болон ЭЗБШӨЧ Төслийн багт чин сэтгэлийн талархлаа илэрхийлье. Та бүхэнтэй хамтран ажиллах нь миний хувьд аз завшаан байлаа.



## ТОВЧИЛСОН ҮГ, ХЭЛЛЭГ

---

АҮХ	Ажил Үүргийн Хуваарь
АНУ-ын ОУХА	АНУ-ын Олон Улсын Хөгжлийн Агентлаг
АС	Азийн Сан
МУ-ын ЗГ	Монгол Улсын Засгийн газар
ОНЗ	Олон Нийтэд Зарлах
ОУБНХ	Бүгд Найрамдахчуудын Олон Улсын Хүрээлэн
ОУВС	Олон Улсын Валютын Сан
СЯ	Санхүү, эдийн засгийн Яам
ТБЕТ	Тооцоолох Боломжтой Ерөнхий Тэнцвэр
ҮТЕГ	Үндэсний Татварын Ерөнхий Газар
ҮХЯ	Үйлдвэр, Худалдааны Яам
ХАМБЗ	Хойд Америк, Монголын Бизнесийн Зөвлөл
ЭЗБШӨЧ	Эдийн Засгийн Бодлогын Шинэтгэл, Өрсөлдөх Чадвар Төсөл
МҮХАҮТ	Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхим



## ГАРЧИГ

---

ТАЛАРХАЛ .....	i
ТОВЧИЛСОН ҮГ, ХЭЛЛЭГ .....	i
ГАРЧИГ .....	i
ЕРӨНХИЙ ТОЙМ .....	i
ХЭСЭГ I: ОРШИЛ .....	1
А. Танилцуулга .....	1
Б. Зөвлөхийн ажил үүргийн хуваарь .....	1
ХЭСЭГ II: МЭДЭЭЛЭЛ ХАРИЛЦААНЫ АЖЛЫН ЗОРИЛГО БА ЗОРИЛТ .....	3
А. Мэдээлэл харилцааны ажлын үндсэн зорилго .....	3
Б. Оролцогч талууд ба зорилт .....	3
ХЭСЭГ III: МЭДЭЭЛЭЛ ХАРИЛЦААНД ТОХИОЛДОХ ГОЛ БЭРХШЭЭЛ .....	7
ХЭСЭГ IV: ОЛОН НИЙТЭД ХҮРГЭХ ИЛГЭЭЛТ БУЮУ МЕССЕЖ .....	9
А. Мессежний орчин .....	9
Б. Олон нийтэд хүргэх гол илгээлт буюу үндсэн мессеж .....	11
ХЭСЭГ V: МЭДЭЭЛЭЛ ХАРИЛЦААНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ .....	15
А. Үйл ажиллагааны жагсаалт .....	15
Б. Үйл ажиллагааны матриц .....	17
В. Үйл ажиллагааны нарийвчилсан мэдээлэл .....	19
Г. Мессеж дамжуулагч .....	25
Д. Мэдээлэл харилцааны ажилд тохиолдох цаашдын бэрхшээл .....	25
ХАВСРАЛТ А: ЗОХИОН БАЙГУУЛСАН УУЛЗАЛТУУД .....	29
ХАВСРАЛТ Б: ТАТВАРЫН ШИНЭЧЛЭЛТИЙН ЯРИЛЦЛАГЫН СЭДВҮҮД .....	33



## **ЕРӨНХИЙ ТОЙМ**

---

### **I. Оршил**

Монгол Улсын Засгийн Газар (МУЗГ) ажиллах хүчин, бизнесийн байгууллагуудын татварын дарамтыг бууруулах, хувийн хэвшлийн өсөлтийг дэмжих, дэлхийн зах зээл дээр Монгол Улсын өрсөлдөх чадварыг сайжруулахад чиглэгдсэн татварын бодлогын шинэчлэл хийх хүсэл эрмэлзэл төгс байна. Төрийн ба хувийн хэвшилд нөлөөлөх бодлогын шинэчлэл, шинэ журмыг дагаж мөрдүүлж улс орны хэмжээнд өөрчлөлт хийхийн тулд тэдгээрийг холбогдох оролцогч нарт мэдээлэх, тайлбарлах сурталчлах ажлыг хийх ёстой.

Өрсөлдөх чадварт тулгуурласан татварын шинэчлэл нь дараахь 6 зорилтыг дэвшүүлсэн байх ёстой гэж ерөнхийдөө хүлээн зөвшөөрдөг. Үүнд:

1. Бизнесийн байгууллагуудын татварын дарамтыг бууруулах, ажлын байрыг бий болгох нөхцлийг бүрдүүлэх замаар улс орны өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх
2. Цалин авагчдын татварын дарамт, хөдөлмөрийн зардлыг бууруулах замаар Монгол Улсын эдийн засгийн цар хүрээг тэлэх
3. Далд эдийн засгийн хэмжээг бууруулах, татварын суурийг нэмэгдүүлэх замаар хууль, журмыг сахиулах зардал, урьдчилан таамаглах боломжгүй байдлыг багасгах зорилгоор татварын удирдлагыг хялбарчлах
4. Татварын ялгаварласан заалтуудыг хасч, дотоодын үйлдвэрлэлийг дэмжих зорилгыг татвартай уялдуулах замаар дотоодын хөрөнгө оруулагчдыг хөхүүлэн дэмжих
5. Татварын дарамтыг хөрөнгө оруулалт/үйлдвэрлэлээс хэрэглээ/өмчлөх эрх рүү шилжүүлэх
6. Санхүүгийн эрүүл орчныг хадгалах

### **II. Мэдээлэл харилцааны ажлын зорилго ба зорилт**

Энэхүү мэдээлэл харилцааны стратегийг хоорондоо харилцан уялдаатай, мэдээлэл харилцааны 4 үндсэн зорилгыг хангах хүрээнд боловсруулав. Үүнд:

- Өрсөлдөх чадварын 6 зорилтыг (дээр дурьдсан) хангах МУ-ын татварын шинэчлэлийг хүлээн зөвшөөрөх, дэмжих
- Нээлттэй хэлэлцүүлэг хийх замаар татвар, татварын шинэчлэлийн талаар ЗГ-ын ил тод байдлыг дэмжих нөхцлийг бүрдүүлэх
- МУ-ын татварын шинэчлэлийн төвд өрсөлдөх чадварыг байлгах
- Ардчилсан төрийн тогтолцоонд төсөв, татварын тухай мэдлэг олгох

### **Оролцогч талууд**

Оролцогч бүх талууд чухал хэдий боловч мэдээлэл харилцааны ажлын төлөвлөгөө нь ойрын хугацаанд МУЗГ-ын байгууллагуудыг илүү чухалчилж байна. Үүний дараа тодорхой татварын шинэчлэлийг идэвхтэй дэмжин ажилладаг бизнесийн томоохон байгууллага, тэдгээрийн төлөөлөгчид орж

байна. Эцэст нь шинэчлэлийн зорилгыг ойлгуулах улмаар татварын хуулийг мөрдүүлэх зорилгоор жижиг аж ахуйн нэгж, нийт иргэд хамрагдаж байна. Энэхүү стратеги нь дараахь талуудыг татан оролцуулна. Үүнд:

#### Засгийн газар

- Ерөнхий Сайд
- Сангийн Яам
- Худалдаа, Үйлдвэрийн Яам
- УИХ-ын дарга, гишүүд

#### Бизнесийн байгууллага

- Томоохон компани, бизнесийн холбоод
- Жижиг, дунд үйлдвэр, аж ахуйн нэгжүүд

#### Бусад

- Хэвлэл мэдээлэл
- Иргэд

### **III. Мэдээлэл харилцааны ажилд тохиолдох гол бэрхшээл**

Дээр дурьдсан мэдээлэл харилцааны ажлын зорилтын хүрээнд энэхүү стратеги нь энэ жил өрсөлдөх чадварыг дэмжсэн татварын шинэчлэлийг хэрэгжүүлэх, хуульчлахад дэмжлэг үзүүлэхийг эрмэлзэнэ. Түүнээс гадна, татварын шинэчлэлээс эдийн засагт эерэг нөлөө үзүүлэх нөхцлийг бүрдүүлэхийн тулд энэхүү шинэчлэлээс үр дүн хүртэх улсын ба хувийн хэвшлийн байгууллагууд нь уг өөрчлөлтийг хийх шалтгаан, гарах үр дүнгийн талаар ойлголттой байх шаардлагатай. Энэхүү стратеги нь дор дурдсан бэрхшээлийг тодорхойлж байна. Үүнд:

- МУЗГ-аас татварын багц шинэчлэлийн төслийг эцэслэн гаргаагүй
- Улс төрийн байр суурь нэгдмэл бус
- Хоорондоо ялгаатай татварын шинэчлэлийн хувилбарууд
- Тусгай ашиг сонирхол
- Сонгуулийн нөлөө
- Эдийн засгийн ойлголт, мэдлэг сул
- Иргэд хоосон амлалтаас залхсан

### **IV. Олон нийтэд зориулсан илгээлт буюу "мессеж"**

#### **Үндсэн мессеж**

МУ-ын татварын шинэчлэлийн талаар олон нийтэд хүргэх үндсэн илгээлт буюу үндсэн мессежийг дараахь байдлаар тодорхойлж болно. Үүнд:

**Ажлын байр, өсөлтийг нэмэгдүүлэх татварын хөнгөлөлт: ирээдүйгээ өөрчлөхөд оролцоцгооё**

*Аæëýí ááéð, 0ñ°ëðèéá íýì ýããççýð òàòáàðúí ò°íá°ë°ëð* гэдэг нь үйл ажиллагаа, үр дүнг тодорхойлсон нэр юм. *Èðýýäçéãýý °°ð-ë°ð°á îðíëõîäáîîî*, гэдэг нь дэмжлэг хүссэн, мөн шинэчлэлийг хэрэгжүүлэхэд оролцохыг уриалан дуудсан уриа юм. Энэхүү үндсэн мессеж нь тодорхой бөгөөд ойлгомжтой: татварын шинэчлэл нь эдийн засгийн өсөлтөд тулгарч буй саад тотгорыг

зайлуулах, ажлын байр бий болгох, илүү олон монголчуудыг эдийн засгийн үйл ажиллагаанд татан оролцуулж, ингэснээр ард түмний амьдралыг сайжруулахад хүргэх хөнгөлөлтийн арга хэрэгслийг бүрдүүлнэ. Уг мессеж нь сүр дуулиантай эсвэл хэтэрхий их зүйлийг амласан бус харин бодитой зүйл юм.

Татварын шинэчлэлийг татварын хөнгөлөлтийн хүрээнд авч үзэж болно. Асуудлыг тодорхой хүрээнд авч үзэх гэдэг нь нааштай үр дүнд хүрэх ажлын талаар эсрэг байр суурьтай хүмүүс байгааг харуулахын зэрэгцээ уг ажлын хүрээг тогтоохыг хэлнэ. Татварын хөнгөлөлт бол сонгодог жишээ юм. Хөнгөлөлт олгохын тулд хүндрэл бэрхшээлтэй тулгарах, үүнийг давж гарсан тал, бэрхшээлийг арилгах улмаар түүний төлөө тэмцэгч, дэмжигч байх ёстой. Дэмжигч талд саад бологч нь хөнгөлөлтийн эсрэг байр суурьтай байгаа гэсэн үг юм.

Хөнгөлөлт гэдэг нь МУ-ын дэвшүүлсэн татварын шинэчлэлийн олон асуудлын хувьд тохиромжтой нэр томъёо юм. *Аæëûí ááéð, ʳñ°ëòèéã íýì ýãã¿¿ýõ òàòáàðûí ò°íã°ë°ëòèéí* тухай мессеж нь дараахь хэсгээс бүрдэнэ. Үүнд:

- Эдийн засгийн хөнгөлөлт
- Татварын хэмжээг багасгах
- Ядуурлыг бууруулах
- Тэгш бус байдлыг арилгах
- Шударга бус байдлыг арилгах
- Шударга бус өрсөлдөөнийг арилгах

*Èðýý¿¿éáýý °°ð-ë°ð°ä îðîëîîãîîî*, гэдэг нь эхлээд татварын шинэчлэлийг хуульчлах, дараа нь татварын хөнгөлөлтөөс үр дүн хүртэхийн тулд арга хэмжээ авахад оролцогч талуудыг дуудсан уриа юм. Энэ бол татварөө төлөх, ингэснээр улс орны эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлэх, ирээдүйг нь тодорхойлоход идэвхтэй оролцохыг уриалсан дуудлага юм. Гол оролцогч талууд татварын хөнгөлөлт бий болгоход оролцсон тохиолдолд л хэрэгжих болно гэсэн мессежийг онцолж байна. *Èðýý¿¿éáýý °°ð-ë°ð°ä îðîëîîîãîîî*, гэдэг уриа нь улс орны ирээдүйг тодорхойлоход оролцох хувь хүний *àì èàèò*, бүх монголчуудын ирээдүйн хөгжилд хувь нэмрээ оруулах *¿¿ðýã òàðèòòèéããà* гэсэн 2 асуудлыг нэгтгэн, шинэчлэлийн үр дүн рүү чиглэгдэнэ.

Практик дээр үндсэн мессежийг тусгасан мэдэгдэл боловсруулах хялбар байдаг. Илүү ач холбогдолтой болгохын тулд тохиромжтой үед нь татвар төлөгчийг дэмжсэн, ажлын байр бий болгохыг дэмжсэн, өсөлтийг дэмжсэн, өрсөлдөөнийг дэмжсэн гэх мэх эсрэг үг хэллэгийг “татварын хөнгөлөлтийг” тайлбарласан тэмдэг нэр болгон ашиглаж болно.

- **Татварын хөнгөлөлт** нь компаниудын хувьд шинээр **ажлын байр** бий болгох замыг нээснээр илүү олон Монголчуудад эдийн засгийн ирээдүйдээ **оролцох** боломжийг олгоно.
- **Татварын хөнгөлөлт** нь татварын хэмжээ адил тэгш болгох замаар бүх монголчуудад **эдийн засгийн өсөлтийг** нэмэгдүүлэхэд оролцоход тус дөхөм үзүүлнэ.
- **Татвар төлөгчийг дэмжсэн татварын хөнгөлөлтийн** багц нь татварын хэмжээг шударга тогтоосноор ажиллагсдад ногдох татварын хэмжээг багасгаж, цалин авагчдын гарт илүү мөнгө олгох болно.

- **Өрсөлдөх чадварыг дэмжсэн татварын хөнгөлөлт** нь бизнесүүдэд ногдох татвар, ажиллах хүчний зардлыг бууруулан, шинэ бүтээл, өсөлтөд нэн шаардлагатай хөрөнгө оруулалтийн эх үүсвэрийг нээнэ.
- **Өсөлтийг дэмжсэн татварын хөнгөлөлт** нь иргэд далд эдийн засгаас татварын төлөгч болон ил гарч ирэх тул төсвийг орлогыг **өсгөж**, шинээр **ажлын байр** бий болгох тул илүү олон хүмүүсийг ажиллах хүчинд нэгтгэн, улс орны эдийн засгийг бүхэлд нь хамарна.

## V. Мэдээлэл харилцааны ажлын төлөвлөгөө

Цаг хугацаа, зорилгын хувьд энэхүү ажлын төлөвлөгөөг дараахь 2 үе шатад хуваана. Үүнд: нэгдүгээрт, татварын асуудлыг хэлэлцэх явцад хэлэлцүүлгийн түвшин, чанарыг дээшлүүлэх зорилгоор богино хугацаанд хийж гүйцэтгэх ажил; хоёрдугаарт, татвар, төсвийн тухай ерөнхий мэдлэгийг дээшлүүлэхийн тулд урт хугацаанд хийж гүйцэтгэх ажил багтаж байна.

### I шат: Татварын хөнгөлөлтийн тухай хэлэлцүүлэг

- Тооцоолох боломжтой ерөнхий тэнцвэр (ТБЕТ)-ийн загварт тулгуурласан адил төстэй татварын арга хэмжээний үр нөлөөний талаарх дугуй ширээний уулзалтыг ЗГ-ын гишүүдэд хийх
- ТБЕТ-ийн загварт тулгуурласан адил төстэй татварын арга хэмжээний үр нөлөөний талаарх дугуй ширээний уулзалтыг УИХ-ын гишүүд/намын бүлгүүдэд хийх
- *Í ýýèòòýé çàñàã* вебсайтын дэмжлэгтэйгээр татварын хөнгөлөлтийн асуудлаар ЗГ, бизнесийн байгууллагуудын нээлттэй уулзалтыг улс орон даяар телевиз, радиогоор нэвтрүүлэх
- *Í ýýèòòýé çàñàã* вебсайтын дэмжлэгтэйгээр татварын хөнгөлөлтийн талаар ярилцлага (чат) зохион байгуулах
- Татварын хөнгөлөлтийн талаар Нээлттэй Нийгэм Хүрээлэнгээс телевизийн нэвтрүүлэг явуулах
- ЗГ-ын хэвлэл мэдээллийн ажилтнуудад мэдээлэл харилцааны ажлыг зохион байгуулахад туслалцаа үзүүлэх (иргэдэд мэдээлэхээс өмнө)
- Татварын хөнгөлөлт үзүүлэх тухай хуулийн төслийг *Í ýýèòòýé çàñàã* вебсайтад тавих (иргэдэд мэдээлсний дараа)
- Татварын хөнгөлөлт үзүүлэх тухай хуулийн төслийг *Í ýýèòòýé Í èéãýì Õ¿ðýýýí àèéí* вэбсайт болон олон нийтэд зориулсан бусад вебсайтад тавих (иргэдэд мэдээлсний дараа)
- Татварын хөнгөлөлтийн асуудлаар сэтгүүлчдэд зориулсан семинарыг СЯ-тай хамтран зохион байгуулах (иргэдэд мэдээлсний дараа)
- Хэвлэл мэдээллийн хэрэгслэлээр сурталчлах

### II шат: Татвар, төсвийн талаарх боловсрол

- Татвар, төсвийн асуудлаар ЗГ-ын албан тушаалтнууд/УИХ-д зориулсан семинар

- Татвар, төсвийн асуудлаар бизнесийн байгууллагуудын удирдлагад зориулсан семинар
- Татвар, төсвийн асуудлаар орон нутгийн бизнес эрхлэгчдэд зориулсан семинар
- Татвар, төсвийн асуудлаар сэтгүүлчдэд зориулсан семинар
- Татвар, төсвийн нүндсэн ойлголт өгөх товхимол/сонин
- ЭЗБШӨЧ Төсөл/Азийн Сангийн дэмжлэгтэйгээр СЯ/ҮХЯ-наас татварын асуудлаарх телевизийн нэвтрүүлэг
- ЗГ-ын телевизийн мэдээллийн хөтөлбөр
- Татвар, төсвийн асуудлаарх радио нэвтрүүлэг
- Татварын хуулийг дагаж мөрдөх талаар олон нийтэд зарлах
- Татвар, төсвийн тухай вебсайтын мэдээллийн хуудас
- ГЭР Санаачлага төслөөс сар тутам гаргадаг бичил бизнесийн сонинтой хамтран ажиллах
- Хэвлэл мэдээллийн хэрэгслэлээр сурталчлах



## **ХЭСЭГ I: ОРШИЛ**

---

### **А. Танилцуулга**

МУЗГ-аас ажилчид, бизнесийн байгууллагуудын татварын дарамтыг бууруулах, хувийн хэвшлийн өсөлтийн нэмэгдүүлэх, дэлхийн зах зээл дээр МУ-ын өрсөлдөх чадварыг сайжруулах татварын бодлогын шинэчлэл хийх хүсэл эрмэлзлэл төгс байна. ЭЗБШӨЧ Төсөл, СЯ, Ерөнхий Сайдын Ажлын Алба, ҮХЯ, УИХ, УИХ-ын гишүүд, ҮТЕГ, мөн бизнесийн хүрээнийхэн, холбогдох байгууллага, иргэний нийгэмд дэмжлэг туслалцаа үзүүлэх замаар татварын шинэчлэлийн хүчин чармайлтыг дэмжиж байна.

Татварын шинэчлэл нь хувийн хэвшлийн өсөлтийг нэмэгдүүлж, хөдөлмөрч иргэдийг ажил эрхлэх боломжоор хангахуйц шударга, ил тод татварын тогтолцоог бий болгох замаар Монгол Улсын бизнес эрхлэгчид, цалин авагчдыг дэмжих зорилготой. Өрсөлдөх чадварт тулгуурласан татварын шинэчлэл нь дараахь 6 харилцан уялдаа холбоотой зорилттой байх ёстой гэсэн ерөнхий зөвшилцөлд хүрээд байна. Үүнд:

1. Бизнесийн байгууллагуудын татварын дарамтыг бууруулах, ажлын байрыг бий болгох нөхцлийг бүрдүүлэх замаар улс орны өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх
2. Цалин авагчдын татварын дарамт, хөдөлмөрийн зардлыг бууруулах замаар Монгол Улсын эдийн засгийн цар хүрээг тэлэх
3. Далд эдийн засгийн хэмжээг бууруулах, татварын суурийг нэмэгдүүлэх замаар хууль, журмыг сахиулах зардал, урьдчилан таамаглах боломжгүй байдлыг багасгах зорилгоор татварын удирдлагыг хялбарчлах
4. Татварын ялгаварласан заалтуудыг хасч, дотоодын үйлдвэрлэлийг дэмжих зорилготой татварыг уялдуулах замаар дотоодын хөрөнгө оруулагчдыг хөхүүлэн дэмжих
5. Татварын дарамтыг хөрөнгө оруулалт/үйлдвэрлэлээс хэрэглээ/өмчлөх эрх рүү шилжүүлэх
6. Санхүүгийн эрүүл орчныг хадгалах

МУ-ын өрсөлдөх чадварыг дээшлүүлэхийн тулд энэхүү нэн шаардлагатай шинэчлэлийг хийх талаар олон нийт нэгдмэл байр суурьтай байх ёстой. Төрийн ба хувийн хэвшилд нөлөөлөх бодлогын шинэчлэл, шинэ журмыг дагаж мөрдүүлж улс орны хэмжээнд өөрчлөлт хийхийн тулд тэдгээрийг холбогдох оролцогч нарт мэдээлэх, тайлбарлах сурталчлах ажлыг хийх ёстой.

### **Б. Зөвлөхийн ажил үүргийн хуваарь**

Энэхүү баримт бичиг нь МУ-д татварын тухай ойлголтыг нэмэгдүүлэх, татварын шинэчлэлийг амжилттай хэрэгжүүлэхийн тулд мэдээлэл, харилцааны оновчтой зорилго, мессеж, үйл ажиллагааг тодорхойлсон мэдээлэл харилцааны стратегийг тусгасан. Энэ стратеги нь санал болгож буй ажлыг хийх үйл ажиллагааны төлөвлөгөө, төсвийг багтааж байна. Зөвлөх өөрийн ажил үүргийн хуваарийн дагуу томилолтынхоо үеэр газар дээр нь санал хүсэлт хүлээн, авч дараахь ажлыг хийж гүйцэтгэсэн. Үүнд:

- Энэхүү санал болгосон стратегийн үр дүнг хүртэж болох томоохон оролцогч талуудыг тодорхойлсон

- Татварын шинэчлэлийг бүхэлд нь дэмжих “үндсэн мессежийг” боловсруулахад МУЗГ-т туслалцаа үзүүлсэн
- Мэдээлэл харилцааны ажлын явцад мессеж дамжуулах ажлыг зохицуулах талаар практик туршлага дээр тулгуурласан сургалтыг ЗГ-ын хэвлэл, мэдээллийн ажилтнууд зориулан зохион байгуулсан
- ЗГ-ын олон нийтийн хэвлэл мэдээллийн ажилтан, СЯ-ны хэвлэл мэдээллийн ажилтнуудтай хамтран олон нийтийг хамарсан мэдээлэл харилцааны ажил зохион байгуулах үйл ажиллагааны төлөвлөгөөний төсөл боловсруулсан
- Олон нийтийг хамарсан хэвлэл мэдээллийн хэрэгслийн ажлыг дэмжих төлөвлөгөө, төсөв гаргасан
- УИХ-ын чуулганы нээлт дээр Ерөнхий Сайдын хэлэх үгэнд зориулсан татварын шинэчлэлийн тухай ярианы сэдвийг бэлтгэсэн
- Монгол дахь АНУ-ын ОУХА-ийн Төлөөлөгчийн Газарт мэдээлэл харилцааны стратегийн талаар товч мэдээллийг хийсэн.

## **ХЭСЭГ II: МЭДЭЭЛЭЛ ХАРИЛЦААНЫ АЖЛЫН ЗОРИЛГО БА ЗОРИЛТ**

### **А. Мэдээлэл харилцааны ажлын үндсэн зорилго**

Энэхүү мэдээлэл харилцааны стратегийг мэдээлэл харилцааны ажлын 4 үндсэн зорилгыг хангах хүрээнд боловсруулав. Үүнд:

- Өрсөлдөх чадварын 6 зорилтыг (дээр дурьдсан) хангах МУ-ын татварын шинэчлэлийг **хүлээн зөвшөөрөх, дэмжих**
- Нээлттэй **хэлэлцүүлэг** хийх замаар татвар, татварын шинэчлэлийн талаар ЗГ-ын ил тод байдлыг дэмжих нөхцлийг бүрдүүлэх
- МУ-ын татварын шинэчлэлийн төвд **өрсөлдөх чадварийг** байлгах
- Ардчилсан төрийн тогтолцоонд төсөв, татварын тухай **мэдлэг** олгох

Эдгээр зорилго нь төр засаг, татвар төлөгчдийн хоорондын мэдээлэл харилцааны сувгуудыг бэхжүүлэх, хэлэлцүүлэгт шаардлагатай үнэн зөв мэдээллийг өгөх замаар татварын шинэчлэлийн эргэн тойронд өрнөж буй ардчилсан үйл явцыг идэвхжүүлэхэд чиглэгдэнэ. Мэдээлэл харилцааны ажлын зорилго нь татварын шинэчлэл хийх тодорхой нэг саналтай шууд уялдаа холбоотой бус харин өрсөлдөх чадварыг дэмжсэн зорилгыг хамгийн сайн хангах байдлыг харгалзсан саналуудыг өрсөлдүүлж шалгаруулах орчныг бий болгоно.

Мэдээлэл харилцааны ажлын өөр хоорондоо уялдаа бүхий 4 үндсэн зорилгыг цаашид дараахь зорилгуудаар тодорхойлно. Үүнд:

- Татварыг тогтвортой хөгжилтэй холбох өрсөлдөх чадварыг дэмжсэн, хэрэглээнд тулгуурласан татварын шинэчлэлийг дэмжсэн “хэнгэрэг дэлдэх”
- Илүү ухаалаг бодлого боловсруулахад тус дөхөм үзүүлэхийн тулд МУЗГ, бизнесийн байгууллагуудад татвар, төсвийн талаар мэдлэг олгох
- Татварын шинэчлэлийн хэлэлцүүлгийг илүү өндөр түвшинд зохион байгуулах арга хэрэгсэл, мэдээллээр хангах
- Хэлэлцүүлгийг төр засгийн үйл ажиллагааны салшгүй хэсэг болгон хэвшүүлэх
- Төр засаг, оролцогч талуудын хоорондын хэлэлцүүлэг, мэдээлэл харилцааны механизмын тоо/чанарыг нэмэгдүүлэх
- Улсын төсөв, зах зээлийн эдийн засаг, татварын үндсэн ойлголтын талаар боловсрол олгох замаар татварын шинэчлэлийн тухай олон нийтийн мэдлэгийг бэхжүүлэх

### **Б. Оролцогч талууд ба зорилт**

Дээр дурьдсан зорилгын хүрээнд дараахь дүр зураг нь гол оролцогч бүлэг тус бүрийн хувьд мэдээлэл харилцааны зорилгыг харуулав. Эдгээр зорилго нь энэхүү төлөвлөгөөнд хожим тайлбарлах мэдээлэл харилцааны тодорхой ажлуудыг сонгоход тус дөхөм үзүүлнэ. Оролцогч бүх талууд чухал хэдий ч мэдээлэл харилцааны ажлын төлөвлөгөө нь ойрын хугацаанд МУЗГ-ын байгууллагуудыг илүү чухалчилж байна. Ерөнхий Сайд ба ЗГ-ын гишүүд нь УИХ-ын гишүүдтэй зөвлөлдөх замаар шинэчлэлийг дэмжсэн тодорхой, үр

дүнтэй саналуудыг гаргах нь нэн шаардлагатай байгаа татварын шинэчлэлийг энэ жилд багтаан хэрэгжүүлэх амжилтын гол шалгуур болно.

Дараагийн шатанд хэрэгжүүлэх үйл явцад татварын шинэчлэлийн төлөө идэвхтэй ажилладаг томоохон бизнесүүд, тэдгээрийг төлөөлдөг байгууллагууд орж байна. ЗГ-ын үйл ажиллагааг ил тод болгох, ЗГ, бизнесийн байгууллага хоорондын хэлэлцүүлгийг сайжруулах нь эдгээр хүчтэй дэмжигч бүлгүүд өрсөлдөх чадварыг дэмжсэн татварын шинэчлэлээс холдох бус харин дэмжих нөхцлийг бүрдүүлнэ. Төр, хувийн хэвшлийн хэлэлцүүлэг нь олон нийтийг хамарсан дугуй ширээний ба хэсэгчилсэн уулзалтаар дамжин явагдаж буйг талархан хүлээн авах нь чухал бөгөөд гол зорилго нь мэдээллийн чанарыг сайжруулах, эдгээр уулзалтад товч тодорхой, хүч нэмэгдүүлсэн мессежийг хүргэхэд оршино.

Эцэст нь шинэчлэлийн зорилгыг ойлгуулж улмаар татварын хуулийг мөрдүүлэх зорилгоор жижиг үйлдвэр, аж ахуйн нэгж, иргэдийг хамруулна. Гэвч шинэчлэлийг хуульчлан батлах эсэхийг тодорхойлох улс төрийн үйл ажиллагаанд тэдний гүйцэтгэх үүрэг нь томоохон бизнесийн байгууллага, ЗГ-тай харьцуулахад харьцангуй бага юм. Эдгээр оролцогч талуудыг цаашид бодлого боловсруулах үйл явцад илүү өргөн хүрээний мэдлэгтэйгээр оролцох нөхцлөөр хангах боловсрол олгох ажлыг эхлүүлэх нь чухал.

Оролцогч талууд	Мэдээлэл харилцааны ажлын зорилго
<b>Засгийн газар</b>	
Ерөнхий сайд	<ul style="list-style-type: none"> <li>Татварын шинэчлэлийн төлөө тэмцэгчийнх нь хувьд дэмжих</li> <li>МУЗГ-ын өрсөлдөх чадварыг дэмжсэн татварын шинэчлэлийг дэмжихэд туслах</li> <li>ЗГ, гол оролцогч талуудын хоорондын хэлэлцүүлгийн тоо/чанарыг нэмэгдүүлэх арга хэрэгсэл, мэдээллээр хангах</li> <li>ЗГ-ын үйл ажиллагааны нэг хэсэг болох хэлэлцүүлгийг гол оролцогч талуудтай хийж хэвшүүлэхийг дэмжих</li> <li>ЗГ-ын хэвлэл, мэдээллийн төлөөлөгчдийн татварын шинэчлэлийг тайлбарлах, сурталчлах чадварыг дээшлүүлэх</li> </ul>
СЯ/ҮХЯ	<ul style="list-style-type: none"> <li>ЗГ-ын өрсөлдөх чадварыг дэмжсэн татварын шинэчлэлийг дэмжихэд туслах</li> <li>Татварын шинэчлэлээс төсөвт үзүүлэх үр нөлөөний талаар санаа зовоосон асуудалд анхаарал хандуулах</li> <li>ЗГ, гол оролцогч талуудын хоорондын хэлэлцүүлгийн тоо/чанарыг нэмэгдүүлэх арга хэрэгсэл, мэдээллээр хангах</li> <li>ЗГ-ын хэвлэл, мэдээллийн төлөөлөгчдийн татварын шинэчлэлийг тайлбарлах, сурталчлах чадварыг дээшлүүлэх</li> </ul>
УИХ-ын дарга, гишүүд	<ul style="list-style-type: none"> <li>Илүү ухаалаг бодлого боловсруулахад тус дөхөм үзүүлэхийн тулд татвар, төсвийн талаарх мэдлэгийг дээшлүүлэх</li> <li>Татварын шинэчлэлээс төсөвт үзүүлэх үр нөлөөний талаар санаа зовоосон асуудалд анхаарал хандуулах</li> <li>Өрсөлдөх чадварыг дэмжсэн татварын шинэчлэлийг одоо хууль болгон батлах улс төрийн дэмжлэгийг авах</li> </ul>
<b>Бизнесийн байгууллагууд</b>	
Томоохон компаниуд,	<ul style="list-style-type: none"> <li>Дотоодын бизнесийн өрсөлдөх чадварт татварын шинэчлэлийн үзүүлэх үр нөлөөг тайлбарлах</li> </ul>

бизнесийн холбоод	<ul style="list-style-type: none"> <li>• Өрсөлдөх чадварыг дэмжсэн татварын шинэчлэлд дэмжлэг авах</li> <li>• Татвар, төсвийн мэдлэгийг дээшлүүлэх</li> <li>• ЗГ-тай хэлэлцүүлэг хийх сувгуудыг бий болгох</li> <li>• Татварын шинэчлэлийг дагаж мөрдөхийг дэмжих</li> </ul>
Жижиг, дунд үйлдвэр, аж ахуйн нэгжүүд	<ul style="list-style-type: none"> <li>• Татварын шинэчлэл, үүнээс жижиг, дунд үйлдвэр, аж ахуйн нэгжүүдэд үзүүлэх үр нөлөөг тайлбарлах</li> <li>• Татвар, төсвийн мэдлэгийг дээшлүүлэх</li> <li>• ЗГ-й хэлэлцүүлэг хийх суваг бий болгох</li> <li>• Татварын шинэчлэлийг дагаж мөрдөхийг дэмжих</li> </ul>
<b>Ерөнхий</b>	
Хэвлэл мэдээллийн хэрэгсэл	<ul style="list-style-type: none"> <li>• Үнэн зөв мэдээллээр хангах нөхцлийг бүрдүүлэх зорилгоор татварын шинэтгэл, үр нөлөөний талаар мэдлэг олгох</li> <li>• Татвар, төсвийн мэдлэгийг дээшлүүлэх</li> </ul>
Иргэд	<ul style="list-style-type: none"> <li>• Татварын шинэчлэлийн талаар мэдлэг олгох</li> <li>• Татварын шинэчлэл, үүнээс ажлын байр, цалинд үзүүлэх үр нөлөөг тайлбарлах</li> <li>• Татварын шинэчлэлийг дагаж мөрдөхийг дэмжих</li> <li>• Татвар, төсвийн мэдлэгийг дээшлүүлэх</li> </ul>



### **ХЭСЭГ III: МЭДЭЭЛЭЛ ХАРИЛЦААНД ТОХИОЛДОХ ГОЛ БЭРХШЭЭЛ**

Мэдээлэл харилцааны ажлын зорилгын хүрээнд энэхүү стратеги нь өрсөлдөх чадварыг дэмжсэн татварын шинэчлэлийг энэ жилд багтаан хуульчлахад дэмжлэг үзүүлэхийг зорьж байна. Үүний тулд хэд хэдэн алхмыг хийх шаардлагатай. Үүнд: ЗГ татварын шинэчлэлийн багц хуулийг УИХ- өргөн барьж, УИХ уг хуулийг энэ хаврын эсвэл намрын чуулганаар хэлэлцэн батлах хүсэл эрмэлзэлтэй байх ёстой. УИХ- нөлөөлөхүйц бизнесийн байгууллага, олон нийтийг төлөөлсөн идэвхтнүүд хуулийг дэмжих эсвэл наад зах нь түүнд хориг саад болохгүй байх ёстой.

Түүнээс гадна энэхүү шинэчлэл эдийн засагт бидний хүссэн нааштай нөлөө үзүүлэх, үр дүнтэй байхад уг татварын шинэчлэлд шууднөлөөлөгдөх улсын салбар болон хувийн хэвшлийн байгууллагууд энэхүү шинэчлэлийг хийх шалтгаан, гарах үр дүнг ойлгох шаардлагатай. Эдгээр оролцогч талууд татварын шинэчлэлийг МУ-н эдийн засгийн эрүүлжилт, өсөлтийг хангах гол арга хэмжээ болохыг хүлээн зөвшөөрөн, санхүүгийн баримт бичгийг үнэн зөв хөтөлж, татвараа шударгаар төлөх замаар өөрсдийн гүйцэтгэх үүрэг хариуцлагыг зөвшөөрөх нь чухал юм.

Энэхүү мэдээлэл харилцааны стратеги нь улсын салбар, хувийн хэвшлийн гол оролцогч тал, бүлэгт хүрч ажиллах замын зураг юм. Стратеги нь дараахь хэд хэдэн гол бэрхшээлийг тодорхойлж байна. Үүнд:

- **ЗГ-н татварын шинэчлэлийн багц эцэслэгдээгүй:** Энэхүү зөвлөх ажлыг гүйцэтгэж байх үед СЯ, ҮХЯ-ы холбогдох газрууд ЗГ-өргөн барих татварын багцын төслийг боловсруулж байсан. Иймээс энэхүү стратеги нь татварын шинэчлэлийн эцсийн хувилбар, мөн гарч болох эсрэг саналын талаар өгүүлэх боломжгүй. Эцсийн хувилбарт зөвшилцөлд хүрсэн тодорхой асуудлуудыг тусган, тэдгээрийг мэдээлэх ажлын хүрээнд мэдээлэл боловсруулж тодорхой ажил төлөвлөнө гэж үзэж байна. Татварын шинэчлэлийн эцсийн хувилбар гарахад эдгээр мэдээлэл, ажлыг хянан засварлах ажлыг дуусгах хэрэгтэй.
- **Улс төрийн байр суурь нэгдмэл бус:** Эвслийн ЗГ татварын шинэчлэлийг хийх хамгийн оновчтой аргын талаар янз бүрийн талуудын гаргасан саналыг тусгана. Татварын шинэчлэлийн хуулийг энэ жил батлахыг дэмжигч талууд шинэчлэлийн үндсэн асуудлаар ерөнхийдөө зөвшилцөлд хүрсэн хэдий боловч эвсэл, түүний дотор яамдын оролцогч талууд шинэчлэлийн талаар нэгдмэл байр суурьтай болж чадаагүй.
- **Хоорондоо ялгаатай, өрсөлдсөн татварын багцууд:** ЗГ-аас эцсийн санал гаргаагүй үед улсын салбар, хувийн хэвшлийн гол оролцогч талууд татварын шинэчлэлийн өөр өөрсдийн хувилбаруудыг олон нийтэд толилуулсан нь ойлгомжгүй байдал үүсгэж, ЗГ-ыг өөрийн татварын шинэчлэлийн багцын талаарх хэлэлцүүлэг удирдан явуулахаас өмнө эдгээр саналд хариу өгөх ёстой байдалд оруулж байна.
- **Тодорхой ашиг сонирхол:** Өөрсдийн бизнес буюу байгууллагад ашигтай байх нөхцлийг бүрдүүлэхийн тулд улс төрийн эрх мэдэлтэй гол оролцогч талуудын дэвшүүлсэн мөрийн хөтөлбөр, ашиг сонирхол нь МУ-ын өнөөгийн мөрдөж буй татварын бүтцэд нөлөөлж ирсэн. Янз бүрийн ашиг сонирхолтой бүлгүүдтэй хэлэлцээр хийх явцад ТБЕТ-ийн загварыг өргөн хүрээнд тараах, баримтжуулах, түүнийг ашиглах талаар сургалт зохион байгуулах нь зүйтэй. Хэлэлцүүлгийг үр дүнтэй явуулж

байх үед татварын шинэчлэлийн адил төстэй хувилбаруудын гарах үр дүнгийн талаар бүх талуудтай санал солилцож боломжтой бөгөөд санал солилцох хэрэгтэй.

- **Сонгуулийн нөлөө:** Удахгүй болох Ерөнхийлөгчийн сонгууль (2005 оны 4 дүгээр сарын 2-ы өдрөөс 5 дугаар сарын 22 хүртэл) ямар нөлөө үзүүлэхийг урьдчилан хэлэх боломжгүй байна. Тулгарах бэрхшээл нь татварын шинэчлэл бус шинэчлэлийн тодорхой асуудлаар хэлэлцүүлэг өрнүүлэх үүднээс ерөнхийлөгчийн сонгуульд хэн ялалт байгуулахаас үл хамааран татварын шинэчлэл нь МУ-н эдийн засгийн өсөлтийг хангахад чухал алхам гэж танилцуулахад оршино. Энэхүү стратегийг бэлтгэх явцад татварын шинэчлэлийг бодит зүйл болгох түлхэц, зөвшилцөл их байгаа нь ажиглагдсан. Энэ жил хэзээ шинэчлэл хийгдэх нь тодорхой бус байна.
- **Эдийн засгийн мэдлэг сул:** Зарим иргэд, бизнесийн байгууллага, ЗГ-н гол оролцогч талуудын татвар, ЗГ-н төсөв, мөн ардчилсан төр засгийн үйл ажиллагааг санхүүжүүлэхэд татварын гүйцэтгэх үүргийн талаарх эдийн засгийн суурь мэдлэг ерөнхийдөө сул байна. МУ зах зээлийн эдийн засагт шилжээд дөнгөж 10 гаруй жил болж байгаа бөгөөд монголын татвар төлөгчид татварын шинэчлэлийн үндэс болох эдийн засгийн зарчмуудыг ойлгож мэдэх нөхцлийг бүрдүүлэхэд үр дүнтэй, эдийн засгийн боловсрол хэрэгцээ шаардлагатай байна.
- **Иргэд амлалтаас залхсан:** Монголчуудын улс төрийн амлалтад итгэх итгэл улам буурч, өөрсдийн амьдралд гарах бодит үр дүнг эрж хайх болсон. БНОУХ-эс саяхан явуулсан санал асуулгаар монголчууд сонгуулиар сонгогдсон улс төрчдийг тэдний амьдралын түвшинг дээшлүүлэх өөрчлөлт хийнэ гэдэгт жилийн өмнөхөөс улам бүр илүү өөдрөг бус ханддаг болсныг харуулжээ. Татварын шинэчлэл нь үр дүн нь харагддаггүй, улс төрийн амлалтын тухай иргэдийн дундах ийм ойлголт руу хальтран орох эрсдэлтэй.

## **ХЭСЭГ IV: ОЛОН НИЙТЭД ХҮРГЭХ ИЛГЭЭЛТ БУЮУ МЕССЕЖ**

---

### **А. Мессежний орчин**

Хамгийн ойлгомжтой байдлаар аваад үзвэл энэхүү мэдээлэл харилцааны стратеги нь татварын шинэчлэлийг дэмжсэн бизнесийн байгууллага, ЗГ хоорондын хэлэлцүүлэг, олон нийтийн боловсролыг дээшлүүлэх хос зорилтыг хангахад чиглэгдэнэ. Эдгээр зорилтыг хангах үйл ажиллагааны цогц төлөвлөгөөг энэхүү тайланд дараа тайлбарлах болно. Гэхдээ хэлэлцүүлэг, боловсрол олгох ажлын хүрээнд хүргэх мессежийг оролцогч талуудад ойлгомжтой хэлээр танилцуулаагүй тохиолдолд мессежийн утга алдагдаж болно.

Ерөнхийдөө хүмүүс тэдний хэтэвч эсвэл сэтгэлд хандсан мессежид хариу өгдөг. Гол оролцогч талуудтай хийсэн уулзалтаас дүгнэхэд тэдний санаа бодлыг тусгасан мессежийг боловсруулах доорх хэд хэдэн сэдвийг гаргаж байна. Үүнд:

- **Замаасаа хазайхгүй байх:** Өрсөлдөх чадварт тулгуурласан татварын шинэчлэлийн олон асуудлын хувьд ерөнхийдөө зөвшилцөлд хүрчээ. Мэдээлэл харилцааны ажил, олон нийтэд зориулсан илгээлт буюу мессеж нь татварын шинэчлэлийн асуудлаар гарсан санал зөрөлдөөнийг гүйцэж татварын шинэчлэлийн ажлыг чиглүүлэх эдгээр зорилгод хүч нэмэгдүүлэхэд чиглэгдэх ёстой. Үүний зорилго нь эдгээр ерөнхий сэдвийн хүрээнд өрнөх хэлэлцүүлгийн цаг хугацааг тогтоон, өнгө аясыг бий болгосноор үндсэн мессежийг шуурхай, тодорхой дамжуулахад оршино.
- **Шинэчлэл хийх цаг:** Уулзаж ярилцсан гол оролцогч талууд жинхэнэ татварын шинэчлэл хийх цаг болсон гэсэн бодолтой байсан. Жил бүр татварын шинэчлэлийн талаар улс төрийн хэлэлцүүлэг болдог хэдий ч энэ жилийн хувьд онцлогтой бөгөөд тэд жинхэнэ үндсэн өөрчлөлт хийх боломжтой гэж хэлсэн. Зарим нь гадаадын хандивлагчид татварын шинэчлэлийг эн тэргүүнд тавьсан гэсэн бодолтой байхад бусад нь татвар төлөгчид, ЗГ татвар төлөхөөс илт зайлсхийж, хоёр нүүр гаргаж ирсэн гэж үзэж байна. Мессеж нь цаг хугацааны шахуу байдал, шинэчлэл хийх боломжийн тухай санал бодлыг тусгах хэрэгтэй.
- **Үнэнч шударга байдал:** Монголчууд эрх тэгш байхтай холбоотой үнэнч шударга байдлын талаар хүчтэй мэдрэмжтэй байна. Хэрэв нэг хэсэг нь татвараа төлөхгүй байхад нөгөө хэсэг татвараа төлж байвал шударга бус хэрэг. Хэрэв бүгд татвараа төлвөл нөгөө хэсэг мөн л татвараа төлөх бөгөөд нь ингэх нь шударга явдал юм. Энэ нь төлөх ёстой татварын талыг нь төлдөг байдал буюу тал нь хоосон, тал нь дүүрэн шилэн аяга шиг харагдаж байна. Хэрэв татвар төлөгчдийн тал хувь нь татвараа төлөхгүй бол нөгөө хэсэг нь тэдний өмнөөс татварыг нь төлөх болно. Үүнийг бид дараахь байдлаар хувь хүний жишээн дээр авч үзэж болно: “хэрэв та татвараа төлөхгүй бол таны татварыг хэн төлөх вэ? Бусдаас татвар авахаа зогсоо” гэх буюу энд ажил дээрээ байгаа ядуу эмэгтэйн дүр зургийг ашиглаж болно. Шударга байдал нь хэт өндөр татварын хэмжээнд нөлөөлдөг. Татварын асуудалд шударга бус, тэгш бус байдлаар хандах нь авилгал, тэгш бус байдлыг даамжруулдаг гэж үздэг. Бүртгэлд орж, НӨТ төлдөггүй жижиг компаниудтай том компаниуд нь өрсөлдөх боломжгүй. Үнэнч шударга байдал бол хүчтэй үзэл баримтлал бөгөөд татварын шинэчлэлийн мессежний гол хэсэг байх ёстой. Гэхдээ энэ нь татварын удирдлага, татвар хураах аргын талаар асуудал гаргаж тавьдаг гэдгийг санах нь зүйтэй.

- **Илэн далангүй яриа:** Татварын шинэчлэл бол чухал асуудал бөгөөд монголчууд шинэчлэл тэдэнд хэрхэн нөлөөлөх талаар удирдагчдын илэн далангүй үгийг сонсохыг хүсч байна. Нааштай эерэг ажил хийх талаар бүрэн дүүрэн сэтгэгдэл төрүүлэхүйц байдаг ч эцэст нь хэрэгжихгүй үлдэх улс төрийн сүртэй урианы талаар сэтгэл дундуур байгаагаа залуу мэргэжилтнүүдээс бүрдсэн хэсэг илэрхийлсэн. Нэг компаний гүйцэтгэх захирал ер нь гадаадын хандивлагчид Монголчуудад хэтэрхий энгийн мэдээлэл өгдөг бөгөөд илүү мэргэжлийн байдлаар хандах хэрэгтэй байна гэж жаахан зэмлэнгүй байсан. Мессеж нь үүнийг анхааралдаа авч ойлгомжтой, мэдрэмжтэй байх ёстой.
- **Шинэ ажлын байр, өндөр цалин:** Бизнесийн гүйцэтгэх захирлуудын тэмдэглэн хэлснээр цалинд ногдуулж буй татвар нь өндөр чадвартай ажилчдыг ажиллуулах, цалинг нэмэгдүүлэх, ажлын байр бий болгоход зардлын хувьд ихээхэн саад тотгор болж байна. Ажил олгогчид цалинд ногдуулж буй өндөр татвар, нийгмийн даатгалын шимтгэлийн улмаас өндөр чадвартай ажилчдыг өндөр цалингаар авч ажиллуулж чадахгүй байна. Ажлын байр бий болгох нь хүн амын тал хувийг 20 хүртэлх насны залуус эзэлдэг улсын хувьд чухал асуудал юм. Мессеж нь татварын шинэчлэл, ажлын байр, өндөр цалингийн хоорондын шууд холбоог онцолж үзэх нь зүйтэй.
- **Эдийн засгийн өсөлт:** МУ татварынхаа хэмжээгээр хөгжиж буй бус харин баян чинээлэг, хөгжилтэй улс орнуудынхтай тэнцэх, дэлхий дээр хамгийн их татварын дарамтад нэрвэгдсэн орнуудын нэг юм. Татварын дарамтыг бууруулахыг зорьж буй татварын шинэчлэл нь цалин авагчдад өөрсдийн олж буй орлогоос илүү хувь хүртэх боломж олгон, ядууралтай хийх тэмцэлд тус дөхөм үзүүлнэ. Энэ нь бизнесийн зардлыг бууруулах, гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдыг татвараас түр чөлөөлж урамшуулахдаа эрх тэгш байдлаар хандах нь дотоодын компаниудын өрсөлдөх чадварыг хөгжүүлнэ. Эдийн засгийн өсөлт нь татварын шинэчлэлийн үндсэн мессеж байх нь дамжиггүй.
- **Ил тод байдал ба далд эдийн засаг:** Бизнесийн байгууллагын удирдагчид зардал, татвараас зайлсхийх эрсдэлд дургүй. Сүүдрийн эдийн засагт үйл ажиллагаагаа явуулж буй бизнесийн байгууллагуудад хууль халдахгүй байх боловч тэднийг хамгаалж өмгөөлөхгүй. Компаний удирдагууд 2 янзын нягтлан бодох бүртгэлийн тайлан хөтөлж, татварын босгоос доогуур байхын тулд корпорациудыг хэд хэдэн жижиг компанид хуваадаг хүндрэлтэй нөхцөл байдал үүссэнд харамсч байсан. Ийм нөхцөл байдал нь бизнесийн өсөлт, томоохон зах зээлд гарахад саад тотгор учруулж байна гэж хэлсэн. Зардал өндөр, хуулийг дагаж мөрдөхгүй байгаагийн үр дагавар, түүнээс үүсэх ойлгомжгүй байдал өргөн тархсаныг бизнес эрхлэгчид “энэ бол бидний буруу биш”, харин татварын өнөөгийн тогтолцоонд хариу үйлдэл хийж байгаа хэрэг гэж байсан. Тэд хэрэв татварын хэмжээ боломжийн түвшинд, татвар хураах аргыг зохистой зохицуулбал тэд орлого, цалингаа бүрэн мэдүүлэн, татвараа төлөхөд бэлэн байгаагаа илэрхийлж байсан. Татварын өршөөл үзүүлэх нь цоо шинээр эхлэхэд маш чухал асуудал хэмээн үзэж байна. Мессеж нь ийм сэтгэл дундуур байдлыг анхааран авч, албан ёсны эдийн засагт шударгаар үйл ажиллагаа явуулах ач холбогдлыг харгалзан үзэх нь зүйтэй.
- **Төсвийн орлогын өсөлт:** Татварын шинэчлэлээс бий болох төсвийн орлогын өсөлт нь илүү нарийн, маргаантай асуудал юм. ЗГ-ын татварын орлого

алдагдалтай байх нь ЗГ дахь зах зээлийн баримжаа багатай, хуучинсаг үзэлтнүүдийн санааг зовоосон, мөн татварын шинэчлэлийг бүрэн хэмжээнд хийх үед эсэргүүцэлтэй тулгардаг гол асуудал юм. Гэвч далд эдийн засагтай тэмцэж буй улс орнуудын туршлагаас харахад бизнесийн байгууллагууд албан ёсны эдийн засагт шилжснээрээ татварын суурийг өргөжүүлж, орлогоо бүрэн мэдүүлэх тул хэт өндөр татварын түвшинг бууруулах нь төсвийн орлогыг нэмэгдүүлдэг болохыг гэрчилж байна. Бусад улс орнуудын туршлага нь бодит тоо баримтад тулгуурласан төсвийн орлогын өсөлтийн талаарх мэдээлэл нь ЗГ, парламент дахь төсвийн хувьд хуучинсаг үзэлтнүүдийн зүгээс дэмжлэг авахад зайлшгүй шаардлагатай аж. Гэвч ЗГ-ын орлого нэмэгдэхийн хэмжээгээр ЗГ-ын хариуцлагатай байдал, төсвийн зарцуулалтын ил тод байдлын асуудлыг гаргаж тавьдаг.

- **Олон нийтийн тусын төлөө:** Татвар гэдэг нь олон нийтийн сайн сайхны төлөө зарцуулагддаг бөгөөд татвар төлөх нь иргэний үүрэг гэсэн үзэл баримтлалыг татварын шинэчлэлийг дэмжих мэдээлэл харилцааны, олон нийтийг хамарсан ажлын бүх мессежид онцолж байх ёстой. Гэвч энэ ажил нь “яагаад татвар төлөх хэрэгтэй вэ?” гэсэн асуултад хариулахын сацуу ЗГ-ын татварын орлого, төсвийн талаар боловсрол олгох урт хугацааны ажлын эхлэлийг тавих ёстой. Татварын орлогоос таны төлөх ёстой зүйлийг төлж байна гэдгийг эхний мессежээр илэрхийлж байна. Татварын орлого бол иргэншсэн нийгэмд амьдрах, ардчилал ба бусад боломжуудоос хүртэх, ЗГ-н бий болгосон дэд бүцтийг ашиглах, засвар үйлчилгээ хийхийн тулд таны оруулж буй хувь нэмэр юм. Хоёрдугаарт, татвар бол хөрөнгө оруулалт. Татварыг ухаалгаар зарцуулж, усан хангамж, хурдны зам, сургууль, коллеж, найдвартай цагдаа, галын аюултай тэмцэх үйлчилгээ гэх мэт нийтийн өмч хөрөнгийг сайжруулж, ирээдүйд шинээр бий болгоход зарцуулдаг. Татварын тухай эдгээр мессежийг олон нийт хүлээн авч, ойлгох хүртэл нь дахин дахин давтаж, улам бүр сайжруулах хэрэгтэй. Энэ ажил цаг хугацаа шаардах ба үүнийг одоо эхлүүлэх хэрэгтэй.

## Б. Олон нийтэд хүргэх гол илгээлт буюу үндсэн мессеж

Үндсэн мессеж гэж бидний мэдээлэл харилцааны ажлын төлөвлөгөөнд тусгасан ажил бүрээр дамжин оролцогч талуудад хүргэх ёстой гол агуулга юм. Энэ нь хүмүүсийн анхаарлын татан, үр дүнг шуурхай мэдээлэх арга болдог. Оролцогч тал бүрт зориулсан мэдээллийг сүүлд тайлбарлах хэдий боловч энд толилуулж буй үндсэн мессеж нь ерөнхий сэдэв, гол оролцогч талуудын сэтгэлийг зовоосон асуудлыг тусгасан татварын шинэчлэлийн хүчин чармайлтын гол сэдэв юм.

МУ-н татварын шинэчлэлийн үндсэн мессежийг дараахь байдлаар тодорхойлж болно. Үүнд:

### **Ажлын байр, өсөлтийг нэмэгдүүлэх татварын хөнгөлөлт: ирээдүйгээ өөрчлөхөд оролцоцгооё**

*Аæëüí áàèð, °ñ°èðèéã Íýí ýããççëýð òàðáàððüí ò°íã°è°èð* гэдэг нь үйл ажиллагаа, үр дүнг тодорхойлсон нэр юм. *Èðýýãçéãýý °°ð-è°ð°ä îðîëîîôäîîî*, гэдэг нь дэмжлэг хүссэн, мөн шинэчлэлийг хэрэгжүүлэхэд оролцохыг уриалан дуудсан уриа юм. Энэхүү үндсэн мессеж нь тодорхой бөгөөд ойлгомжтой юм: татварын шинэчлэл нь эдийн засгийн өсөлтөд тулгарч буй саад тотгорыг зайлуулах, ажлын байр бий болгох, илүү олон монголчуудыг эдийн засгийн үйл ажиллагаанд татан оролцуулж, ингэснээр ард түмний амьдралыг

сайжруулахад хүргэх хөнгөлөлтийн арга хэрэгслийг бүрдүүлнэ. Уг мессеж нь сүр дуулиантай эсвэл хэтэрхий их зүйлийг амласан бус харин бодитой зүйл юм.

Энгийн, мартагдахгүй үндсэн мессежийг байнга давтах нь татварын шинэчлэлийн хүчин чармайлтыг ойлгох, хүлээн зөвшөөрөх, эцэст нь амжилтад хүргэхэд чухал ач холбогдолтой. Байнга хэрэглэгдэж, давтагдаж байсан мессеж нь хүсэн хүлээсэн зүйл, татварын шинэчлэлийг хуульчлан, олон нийт хүлээн зөвшөөрч дагаж мөрдөх хүртэл тасралтгүй үргэлжлэх “хэнгэрэг дэлдэх” эхлэлийг тавина. Уг мессежийг хэрэглэх, гол үг, хэллэгийг гаргаж авахад дөхөм болохын тулд бид түүнийг үндсэн хэсгүүдэд хувааж байна.

### **Б1. Асуудлыг тодорхой хүрээнд авч үзэх - шинэчлэл бус хөнгөлөлт**

Улс төрийн мэдээлэл харилцааны ертөнцөд үг бүрийг тооцдог. Татварын шинэчлэл гэдэг үгийг сонссон хүн татварын тогтолцоонд өөрчлөлт гарна гэж ойлгох хэдий боловч энэ өөрчлөлт нь сайн эсвэл муу эсэх талаар ямар нэг мэдээлэл эсвэл түүний ач холбогдлын талаар хийсэн дүн шинжилгээ байдаггүй. Гэтэл хэрэв бид татварын хөнгөлөлт гэсэн нэр томъёог хэрэглэвэл уг асуудлыг тодорхой хүрээнд ойлгомжтой авч үзсэн ач холбогдлыг нэмж хэлж өгч байна. Ийм үед хөнгөлөлтийг хүн яаж эсэргүүцэх вэ?

Асуудлыг тодорхой хүрээнд авч үзэх гэдэг нь АНУ-ын улс төрийн мэдээлэл харилцааны ажилтнуудын хөгжүүлж төлөвшүүлсэн мэдээлэл харилцааны чадвар юм. Энэ бол нааштай үр дүнд хүрэх ажлын талаар эсрэг байр суурьтай хүмүүс байгааг харуулахын зэрэгцээ уг ажлын хүрээг тогтоохыг хэлнэ. Татварын хөнгөлөлт нь АНУ болон бусад улс орнуудад түгээмэл хэрэглэгдэж буй нэр томъёо болохын хувьд сонгодог жишээ юм. Хөнгөлөлт олгохын тулд хүндрэл бэрхшээлтэй тулгарах, үүнийг давж гарсан тал, бэрхшээлийг арилгах улмаар түүний төлөө тэмцэгч, дэмжигч байх ёстой. Дэмжигч талд саад бологчид нь хөнгөлөлтийн эсрэг байр суурьтай байгаа гэсэн үг юм.

Хөнгөлөлт нь МУ-ын дэвшүүлж буй татварын шинэчлэлийн олон асуудлын тохиромжтой нэр томъёо юм. Ажлын байр, өсөлтийг нэмэгдүүлэх татварын хөнгөлөлтийн тухай мэдээлэл нь дараахь хэсгээс бүрдэнэ. Үүнд:

- **Эдийн засгийн хөнгөлөлт:** Татварын хөнгөлөлт нь татварын хэмжээг бууруулж ажилсаг иргэдэд хөдөлмөр эрхлэх боломж олгох, хувийн хэвшлийн өсөлтийг нэмэгдүүлэн, монголын бизнесийн өрсөлдөх чадварийг нэмэгдүүлэх замаар бүх монголчуудын амьдралыг дээшлүүлэхэд тус дөхөм үзүүлнэ.
- **Татварыг хөнгөлөх:** Татварын хөнгөлөлт нь хувь хүмүүс, бизнесийн байгууллагуудын татварын хэмжээг бууруулж, МУ-ын татварын хэмжээг адил төстэй, шинээр хөгжиж буй эдийн засагтай улс орнуудын түвшинд хүргэнэ.
- **Ядуурлыг бууруулах:** Татварын хөнгөлөлт нь цалин нэмэгдүүлэх нөхцлийг бүрдүүлэх, ажилчдад татварын хэмжээг бууруулах замаар олж буй орлогоос нь илүү өндөр хувийг хүртэх боломж олгох, шинэ ажлын байр бий болгох замаар олон хүнийг ажилтай болгосноор ядууралтай тэмцэнэ.
- **Тэгш бус байдлыг арилгах:** Татварын хөнгөлөлт нь бүх бизнесийн байгууллага, иргэдэд татвараа төлөх урам зориг төрүүлэх, бүх монголчуудад ЗГ-ын үйлчилгээний зардлыг шударгаар хуваарилах замаар татварын тогтолцоонд үнэнч шударга байдлыг сэргээнэ.

- **Шударга бус байдлыг арилгах:** Татварын хөнгөлөлт нь орлого, ажлын хөлс, орлогын өсөлтийг нуун дарагдуулах шударга бус, зардал ихтэй тогтолцооноос ёс суртахууны хувьд чөлөөлөх замаар компани, иргэдийг далд эдийн засгаас ил гарч, албан ёсны эдийн засагт шилжихэд тус дөхөм үзүүлнэ.
- **Шударга бус өрсөлдөөнийг бууруулах:** Татварын хөнгөлөлт нь бизнесийн зардлыг бууруулах, гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдыг татвараас түр чөлөөлж урамшуулахдаа эрх тэгш байдлаар хандан, дотоодын бизнесүүдийг илүү өрсөлдөх чадвартай болгоно.

Асуудлыг тодорхой хүрээнд авч үзэх энэхүү хүчтэй аргын үр нөлөөг бататгахын тулд бүх мессеж нь шинэчлэл гэсэн нэр томъёог хасч бүх тохиолдолд түүнийг хөнгөлөлт гэдэг үгээр орлуулах шаардлагатай. Оролцогч талуудын санал бодлыг өөрчлөхийн тулд эхлээд хэвлэл мэдээллийн ажилтнуудын санал бодлыг өөрчлөх шаардлагатай.

## Б2. Үйл явцыг эхлүүлэх уриа - ирээдүйгээ өөрчлөхөд оролцоцгооё

*ᠡᠳᠦᠶ᠋ᠠᠵᠡᠭᠡᠭᠡᠢ ᠶ᠋ᠢᠨ ᠶ᠋ᠢᠨ ᠶ᠋ᠢᠨ ᠶ᠋ᠢᠨ ᠶ᠋ᠢᠨ*, гэдэг нь оролцогч талуудыг эхлээд хуулийг батлуулах, дараа нь татварын хөнгөлөлтийн үр дүнг хэрэгжих нөхцлийг бүрдүүлэх талаар ажиллахад дуудсан уриа юм. Энэ оролцох, хүрээлэлд орох нэгдсэн хүчин чармайлтыг хүлээж байгаа учраас таны хувь нэмэр оролцоо чухал юм. Үүгээр татвар төлөх, татвараа төлснөөр улс орны эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлэх ирээдүйг тодорхойлоход идэвхтэй оролцохыг уриалж байгаа юм.

Энэхүү уриа нь гол оролцогч талууд татварын хөнгөлөлт бий болгоход оролцсон тохиолдолд хэрэгжих болно гэсэн мэдээллийг онцолж байна. ЗГ-ын удирдагч, хууль тогтоогчид татварын хөнгөлөлт үзүүлэхийг хуулийг батлах нөхцлийг бүрдүүлэх замаар оролцох хэрэгтэй. Бизнес, иргэний нийгмийн байгууллагын удирдагчид татварын хөнгөлөлтийг дэмжих үг хэлэх, сонгуулийн тойргуудад татварын хөнгөлөлтийн талаар мэдлэг олгох, ЗГ-ын албан тушаалтнуудад хуулийг батлуулах талаар нөлөө үзүүлэх замаар оролцох хэрэгтэй. Бүх гол оролцогч талууд улсын салбар, хувийн хэвшлийн хоорондын хэлэлцүүлэг, татварын хөнгөлөлтийн тухай мэдлэгийг нэмэгдүүлэх мэдээлэл харилцааны үйл ажиллагаанд оролцох ёстой.

Хууль тогтоох ажлын дараа *ᠡᠳᠦᠶ᠋ᠠᠵᠡᠭᠡᠭᠡᠢ ᠶ᠋ᠢᠨ ᠶ᠋ᠢᠨ ᠶ᠋ᠢᠨ ᠶ᠋ᠢᠨ*, улс орны ирээдүйг тодорхойлоход оролцох амлалт, бүх монголчуудын ирээдүйн хөгжилд хувь нэмрээ оруулах үүрэг хариуцлагыг хамарсан шинэчлэлийн үр дүн тэнцвэртэй байх тал руу чиглэгдэнэ.

Оролцох амлалт нь иргэдэд улс орны ирээдүйг тодорхойлоход гүйцэтгэх үүрэг хийх сонголт байдаг гэсэн ардчилсан үзэл санааг хүчтэй болгодог. Энэ нь иргэдээс одоо сул байгаа МУ-ын иргэний нийгмийг хөгжүүлэх арга хэмжээ авахыг уриалж байна. Энэ үйл ажиллагаанд оролцох сонголтоо хийж, өөрийн дуу хоолойг сонгож, өөрийн төсөөлж буй ирээдүйд хүрэхийн төлөө ажиллая. Өөрийн татварын мөнгийг өөртөө зориулахын тулд төлбө. Татварын хөнгөлөлт, илүү эдийн засгийн өсөлтийг шаардаж одоо ажиллаж эхлэе. Дараа нь татварын хөрөнгөөр бүрдсэн ЗГ-ын үйлчилгээний чанар, иргэдэд хүргэх ажлыг сайжруулах үүднээс орлогыг зарцуулах тал дээр ЗГ-ын хариуцлагыг бий болгоход оролцье. Та нөлөөлж чадна. Энэ үйл явцад оролцож эдийн засгийн ирээдүйгээ гартаа авъя.

Нөгөө талаас, татварын хэмжээг тэнцвэртэй тогтооход оролцох нь иргэдийн үүрэг хариуцлага бөгөөд татварын хөнгөлөлт нь татварын дарамтыг бууруулдаг. Одоо төлөх татвараа шударгаар төлж МУ-ын эдийн засгийн ирээдүйг өөрчлөхөд идэвхтэй үүрэг гүйцэтгэж оролцох нь таны үүрэг юм. Энэхүү уриа нь дэмжигчдийн тоо нэмэгдэхийн хирээр хүч нэмэгдэж буйг илтгэдэг. Татварын хөнгөлөлт нь хуурч мэхлэх нөхцлийг хааж, оролцох боломжийг бүрдүүлдэг. Мөн шинэ ажлын байр нь ажиллах хүчийг нэмэгдүүлэх тул илүү олон монголчуудыг хамарна. Бэрхшээлийг давж туулахын тулд гэрт нь ирсэн зочныг зүрх сэтгэлээсээ угтан авах ёстой гэдгийг ухамсарлан, нүүдэлчин ард түмний бие биеэсээ хамааралтай, өөр хоорондоо холбоотой амьдардаг гэдэг мэдрэмжид тулгуурласан байх нь зүйтэй. Энэ үйл явцад оролцож МУ-д тусласнаар илүү цэцэглэн хөгжсөн ирээдүйд хүрнэ.

### Б3. Үндсэн мессеж

Практик дээр дээр дурьдсан хөнгөлөлтийн тухай мессеж уг ажилд оролцохыг уриалсан уриатай хослуулан үндсэн мессежийг тусгасан мэдэгдэл боловсруулах хялбар байдаг.

- **Татварын хөнгөлөлт** нь компаниудын хувьд монголчуудад эдийн засгийн ирээдүйд **оролцох** боломж олгон, шинээр **ажлын байр** бий болгох арга замыг нээж өгнө.
- **Татварын хөнгөлөлт** нь татварын хэмжээг адил тэгш болгох замаар бүх монголчуудад **эдийн засгийн өсөлтийг** нэмэгдүүлэхэд оролцоход тус дөхөм үзүүлнэ.
- **Татварын хөнгөлөлт** нь компани, хувь хүмүүсийг далд эдийн засгаас ил гарч, албан ёсны эдийн засагт шилжин, хариуцлагатай татвар төлөгч болж **оролцохыг** уриална.

Илүү онцлон тэмдэглэхийн тулд тохиромжтой үед нь татвар төлөгчийг дэмжсэн, ажил байр бий болгохыг дэмжсэн, өсөлтийг дэмжсэн, өрсөлдөөнийг дэмжсэн зэрэг эерэг үг хэллэгийг татварын хөнгөлөлтийг тайлбарласан тэмдэг нэр болгон ашиглаж болно.

- Энэхүү **татвар төлөгчийг дэмжсэн татварын хөнгөлөлт** нь цалин авагчдын гарт илүү мөнгө өгөх илүү шударга татварын хэмжээ тогтоож, ажилчдын татварын дарамтыг бууруулна.
- **Өрсөлдөх чадварыг дэмжсэн татварын хөнгөлөлт** нь шинэ бүтээл, өсөлтийг дэмжсэн хөрөнгө оруулалтад чухал шаардлагатай хөрөнгийг гарган, татвар, бизнес эрхлэх хөдөлмөрийн зардлыг бууруулна.
- **Өсөлтийг дэмжсэн татварын хөнгөлөлт** нь хүмүүс далд эдийн засгаас ил гарч, татварын төлөгч болох тул төсвийн орлогын өсөлтийг нэмэгдүүлж, шинээр **ажлын байр** бий болох тул илүү олон хүмүүсийг ажиллах хүчинд нэгтгэн, улс орны эдийн засгийг бүхэлд нь хамарна.

## ХЭСЭГ V: МЭДЭЭЛЭЛ ХАРИЛЦААНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

---

Үйл ажиллагааны энэхүү төлөвлөгөө нь үндсэн зорилтот бүлгүүдтэй харьцахад ашиглаж болох санал болгож буй арга хэмжээний газрын зураг юм. Төлөвлөгөө нь янз бүрийн зорилттой 2 хэсгээс бүрдэх ба үүнд татварын багц хуулийн талаар ярилцах ярилцлагын чанар, түвшинг сайжруулах асуудлыг богино хугацаанд дуусгах арга хэмжээ мөн татвар, төсвийн талаарх ерөнхий ойлголтыг сайжруулах урт хугацааны үргэлжилсэн сургалт багтаж байгаа юм.

Арга хэмжээ тус бүрээр нарийвчилсан мэдээллийг өгсөн бөгөөд санал болгож буй арга хэмжээ нь оролцогч тал бүрт чиглэсэн мэдээлэл харилцааны тусгай зорилгод хэрхэн хүрэх талаар тусгай хүснэгтээр үзүүлсэн болно. Бүх арга хэмжээнүүдийн талаар түнш байгууллагуудтай зөвхөн урьдчилсан байдлаар тохирсон байгаа гэдгийг анхаарна уу.

Энэхүү төлөвлөгөөнд үндэслэн мөн байгаа нөөц бололцоогоо ашиглан МУЗГ энд дурьдагдсан гол үйл ажиллагаанаас сонголт хийж, шаардагдах санхүүгийн дэмжлэг авах талаар ЭЗБШӨЧ Төсөл, Азийн Сантай хамтран ажиллаж болох юм. Мэдээлэл харилцааны стратегийг хэрэгжүүлэх явцад арга хэмжээ тус бүрээр нарийвчилсан төлөвлөгөө гаргах шаардлагатай бөгөөд төлөвлөгөөнд юу хийх, хэн хариуцаж гүйцэтгэх болон тухайн асуудалтай холбоотой бусад мэдээллийг тусгасан байх нь зүйтэй. Олон нийтэд зориулсан илгээлт буюу мессежийг дамжуулах хэрэгслийн талаар энэ хэсэгт мөн өгүүлэх болно.

### А. Үйл ажиллагааны жагсаалт

#### А1. Татварын хөнгөлөлтийн талаарх ярилцлага

1. ТБЕТ-ийн загварт тулгуурласан татварын зохицуулалтын хувилбаруудын эдийн засагт үзүүлэх нөлөөллийн загварын талаар ЗГ-ын гишүүдэд зориулсан дугуй ширээний уулзалтыг зохион байгуулах
2. ТБЕТ-ийн загварт тулгуурласан татварын зохицуулалтын хувилбаруудын эдийн засагт үзүүлэх нөлөөллийн загварын талаар УИХ-ын гишүүд, намууд бүлгүүдэд зориулсан дугуй ширээний уулзалтыг зохион байгуулах
3. *Í ýýèðòýé Çàñàà* вэбсайтаас ивээн тэтгэж, татварын хөнгөлөлтийн талаар ЗГ, бизнесийн төлөөлөгчдийн уулзалтыг зохион байгуулан, үндэсний телевиз, радиогоор дамжуулах
  - а) Уулзалтын бичлэгийг хянаж, сонирхогч талуудад тарааж өгөх
  - б) Уулзалтын бичлэгийг хянаж, *Í ýýèðòýé Çàñàà* вэб сайтад байрлуулах
4. *Í ýýèðòýé Çàñàà* вэб сайтаас ивээн тэтгэн татварын шинэтгэлийн талаар онлайн шууд ярилцлагыг интернэтээр зохион байгуулах
  - а) Үйлдвэр, Худалдааны болон Сангийн сайд нар
  - б) УТЕГ-ын дарга ноён Л. Зоригт (Татвар төлөгчдийн 7 хоног, 5 дугаар сарын 13)
5. Татварын шинэтгэлийн талаар *Í ýýèðòýé Í èéãýì Õîððì ààì* телевизийн нэвтрүүлэг бэлтгэх боломж
  - а) Нэвтрүүлгийн бичлэгийг *Í ýýèðòýé Í èéãýì Õîððì ùí* вэб сайтад байрлуулах

6. МУЗГ-ын хэвлэл мэдээллийн албаны ажилтнуудад мэдээлэл харилцааны асуудлыг зохицуулах талаар туслалцаа үзүүлэх (олон нийтэд мэдээлэл хүргэхээс өмнө)
  - а) Татварын шинэтгэлийн талаарх мэдээ
  - б) Татварын шинэтгэлийн талаар ярилцах гол сэдэв
  - в) Хуулийн төслийг танилцуулах хэвлэлийн бага хурлыг төлөвлөх
  - г) Татварын шинэтгэлийн талаарх асуулт, хариулт
7. Татварын шинэтгэлийн тухай хуулийн төслийг *Í úýèòòýé Çàñàã* вэбсайтад байрлуулах (олон нийтэд мэдээлсэний дараа)
  - а) *Í úýèòòýé Çàñàã* вэб сайтын сарын Цувралд нийтлэх
  - б) *Í úýèòòýé Çàñàã* вэб сайтын сонинд нийтлэх
  - в) *Í úýèòòýé Çàñàã* вэб сайтын нүүр хуудсанд байрлуулах
8. Татварын шинэтгэлийн тухай хуулийн төслийг *Í úýèòòýé Í èèãýì Òîðòî ùí* вэб сайт болон олон нийтийн байгууллагын бусад вэб сайтуудад байрлуулах (олон нийтэд мэдээлсэний дараа)
  - а) Татварын шинэтгэлийн явцыг ажиглах тусгай вэб хуудсыг бий болгох
9. СЯ болон сэтгүүлчдийн дунд Татварын шинэтгэл сэдэвт дугуй ширээний ярилцлагыг зохион байгуулах (олон нийтэд мэдээлсэний дараа)
10. Хэвлэл мэдээллийн хэрэгслийг ашиглах
  - а) Сонирхогч, оролцогч талуудын ярилцлага, мэдээ/асуудал дэвшүүлсэн нийтлэл
  - б) Олон нийтэд нөлөө үзүүлэхүйц өгүүллэг, нийтлэл

#### **A2. Татвар болон төсвийн талаар боловсрол олгох тухай**

1. ЗГ-ын албан тушаалтнууд/УИХ-ын гишүүдэд татвар, төсвийн талаар сургалт семинар зохион байгуулах
2. Бизнесийн байгууллагуудын удирдлагад татвар, төсвийн талаар сургалт семинар зохион байгуулах
3. Хөдөөгийн бизнес эрхлэгчдэд татвар, төсвийн талаар сургалт семинар зохион байгуулах
4. Сэтгүүлчдэд татвар, төсвийн талаар сургалт семинар зохион байгуулах
5. Татвар, төсвийн талаар танилцуулга, сонин гаргах
  - а. Тараах
  - б. ХААН банкны салбаруудаар дамжуулан хөдөөгийн бизнес эрхлэгчдэд хүргэх
  - в. МҮХАҮТ, бизнесийн нийгэмлэгүүдээр дамжуулан орон нутгийн бизнес эрхлэгчдэд хүргэх
  - г. Бизнес/ЗГ-ын үйл ажиллагааны сэдвээр мэргэшсэн сэтгүүлчид
  - д. Татварын газрууд ба СЯ-ны байранд үнэгүй тараах
  - е. Нээлттэй Нийгэм Мэдээллийн Төвөөр үнэгүй тараах
  - ж. *Í úýèòòýé Çàñàã* вэб сайтын сарын Цувралд нийтлэх
6. ЭЗБШӨЧ Төсөл, Азийн Сангийн тусламжтайгаар татварын асуудлаар СЯ-наас телевизийн нэвтрүүлэг бэлтгэн явуулах
  - а. Жүжигчилсэн болон танин мэдэхүйн хэлбэрээр
  - б. Сонин, болон вэб сайтад танин мэдэхүйн мэдээлэл байрлуулах

7. ЗГ-ын телевизийн мэдээний цагаар нэвтрүүлэх
8. Татвар, төсвийн талаар радио нэвтрүүлэг хийх
  - а. РАСТ-ын хөдөөгийн малчдад зориулсан нэвтрүүлгээр татварын талаар мэдээлэл нэвтрүүлэх
  - б. СЯ-ны хөтөлбөрийн талаарх татварын мэдээлэл
9. Олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр татварын талаарх мэдээлэл
  - а. Телевиз
  - б. Радио
  - в. Сонин
10. Татвар, төсвийн талаар вэб сайтыг мэдээллийн хуудас нээж ажиллуулах
  - а. *Í ýýèððýé Çàñàà* вэб сайт
  - б. *Í ýýèððýé Í èèäýì Òìðòì ùí* вэб сайт
  - в. СЯ-ны вэб сайт
  - г. Бусад
11. ГЭР Санаачлага төслийн сар тутмын бичил бизнесийн сонинтой хамтран ажиллах
  - а. Татварын талаарх мэдээлэл, нийтлэл
  - б. Асуулт, хариултын булан
12. Хэвлэл мэдээллийн хэрэгслэл
  - а. Мэдээ, сурвалжлага
  - б. Асуудал дэвшүүлсэн нийтлэл
  - в. Нөлөө үзүүлэхүйц нийтлэл

#### Б. Үйл ажиллагааны матриц

Зорилтот бүлэг	Гүйцэтгэвэл зохих арга хэмжээ	Санал болгож буй сувгууд
<b>Засгийн газар</b> ЗГ-ын бодлого боловсруулагчид <ul style="list-style-type: none"> <li>• Ерөнхий сайд</li> <li>• СЯ</li> <li>• ҮХЯ</li> <li>• Засгийн Газар</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Өрсөлдөх чадварт тулгуурласан татварын шинэтгэлийн багц хуулийн төслийг боловсруулах</li> <li>• ЗГ-ын гишүүдийг зөвшилцөлд хүргэх засгийн газар хоорондын хамтын ажиллагааг бэхжүүлэх</li> <li>• Сонирхогч талуудтай нээлттэй ярилцлага хийх замаар МУЗГ-ын ил тод байдлыг дээшлүүлэх</li> <li>• Хуулийг одоо батлуулахын тулд УИХ-тай хамтран ажиллах</li> <li>• Татвар, төсвийн талаар байнга боловсрол олгох үйл явцыг дэмжих</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• ЭЗБШӨЧ Төсөл: Татварын загвар танилцуулах дугуй ширээний ярилцлага зохион байгуулах</li> <li>• ЗГ, бизнесийнхэнтэй уулзалт зохион байгуулах</li> <li>• <i>Í ýýèððýé Çàñàà</i> вэб сайтад хуулийн төслийг байрлуулах</li> <li>• <i>Í ýýèððýé Í èèäýì Òìðòì ùí</i> вэб сайтад хуулийн төслийг байрлуулах</li> <li>• <i>Í ýýèððýé Çàñàà</i> вэб сайтыг мэдээллийн буланд хуулийн төслийг байрлуулах</li> <li>• <i>Í ýýèððýé Çàñàà</i> вэб сайтаар дамжуулан онлайн ярилцлага зохион байгуулах</li> <li>• Татварын шинэтгэлийн талаар <i>Í ýýèððýé Í èèäýì Òìðòì ùí</i> телевизийн нэвтрүүлэг хийх</li> <li>• Татварын шинэтгэлийн талаар хэвлэлийн бага хурал зохион байгуулах</li> <li>• ЗГ-ын хэвлэл, мэдээллийн албаны ажилтнуудад мэдээлэл харилцааны асуудлыг зохицуулах талаар дэмжлэг үзүүлэх</li> </ul>



	ойлголтыг дээшлүүлэх	илэрхийлсэн нийтлэл <ul style="list-style-type: none"> <li>Татвар, төсвийн талаарх танилцуулга хэвлүүлэх</li> <li>Татвар, төсвийн талаарх сургалт семинар зохион байгуулах</li> <li>Татвар, төсвийн талаарх телевизийн нэвтрүүлэг бэлтгэх</li> </ul>
Олон нийт	<ul style="list-style-type: none"> <li>Татварын хуулиудтай уялдуулах</li> <li>Татварын шинэтгэлийг ойлгож дэмжих</li> <li>Мэдээллийн эх сурвалжуудаар дамжуулан татвар, төсвийн талаарх ойлголтыг нэмэгдүүлэх             <ul style="list-style-type: none"> <li>Эдийн засгийн боломжийг дээшлүүлэхэд ЗГ идэвхтэй хамтран ажиллаж буйг харуулах</li> </ul> </li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Татвар, төсвийн талаарх танилцуулга хэвлүүлэх</li> <li>Татвар, төсвийн талаарх мэдээллийг вэб хуудсанд байрлуулах</li> <li>Татвар, төсвийн талаарх телевизийн нэвтрүүлэг бэлтгэх</li> <li>Олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилгаа, мэдээлэл дамжуулахад оролцох</li> </ul>

## В. Үйл ажиллагааны нарийвчилсан мэдээлэл

### В1. Татварын шинэтгэлийн талаарх ярилцлага зохион байгуулахыг дэмжих

#### 1. ЗГ-ын гишүүдэд танилцуулах дугуй ширээний ярилцлага

Хариуцагч: ЭЗБШӨЧ Төслийн мэргэжилтнүүд  
 Хамтран оролцогч: Ерөнхий Сайдын Ажлын Алба  
 Хугацаа: Татварын багц хуулийн эцсийн хувилбарыг ЗГ-т танилцуулахын өмнө

Төслийн мэргэжилтнүүд ТБЕТ-ийн загварыг ашиглан татварын зохицуулалтын хувилбаруудын эдийн засагт үзүүлэх нөлөөллийн талаар хийсэн судалгааны үр дүнгийн талаар ЗГ-ын гишүүдэд танилцуулна. Ингэснээр ЗГ ба ЭЗБШӨЧ Төслийн татварын мэргэжилтнүүдийн хооронд ЗГ-аас санал болгож татварын шинэтгэлийн зорилгод хүрэх арга зам болон татварын төлөвлөж буй нөлөөллийн талаар хаалттай хэлэлцүүлэг хийх боломжийг олгоно.

#### 2. УИХ-ын гишүүд/намуудын бүлэгт танилцуулах

Хариуцагч: ЭЗБШӨЧ Төслийн мэргэжилтнүүд  
 Хамтран оролцогч: Ерөнхий Сайдын Ажлын Алба  
 Хугацаа: Хуулийн төслийг УИХ-ын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэхээс өмнө

Төслийн мэргэжилтнүүд ТБЕТ-ийн загварыг ашиглан татварын зохицуулалтын хувилбаруудын эдийн засагт үзүүлэх нөлөөллийн талаар хийсэн судалгааны үр дүнгийн талаар УИХ-ын гишүүдэд танилцуулна. Ингэснээр УИХ-ын гишүүд, намуудын бүлгийн тэргүүлэгчид, ЭЗБШӨЧ Төслийн татварын мэргэжилтнүүдийн хооронд ЗГ-аас санал болгож татварын шинэтгэлийн зорилгод хүрэх арга зам болон татварын төлөвлөж буй нөлөөллийн талаар татварын хуулийн төслийг УИХ-ын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэхээс өмнө хаалттай хэлэлцүүлэг хийх боломжийг олгоно.

**3. Нээлттэй Засаг вэб сайтаас ивээн тэтгэн “Татварын шинэтгэл” сэдэвт ЗГ, бизнес эрхлэгчдийн хооронд уулзалт зохион байгуулж үндэсний радио телевизээр дамжуулах**

Хариуцагч: Азийн Сан/ЭЗБШӨЧ Төсөл  
Хамтран оролцогч: Ерөнхий Сайдын Ажлын Алба, СЯ, МХАҮТ  
Хугацаа: Татварын шинэтгэлийн багц хуулийн эцсийн хувилбарыг ЗГ-т танилцуулахын өмнө

ЗГ-ын ба бизнесийн салбарын төлөөлөгчдийн татварын шинэтгэлийн талаар хийх нээлттэй хэлэлцүүлгийг үндэсний радио телевизээр дамжуулан зохион байгуулснаар МУЗГ татварын шинэтгэлийн хуулийн төслийн талаар ард иргэдийн саналыг сонсох боломж олгох юм. Хэлэлцүүлэгт оролцогсдыг нийтэд зарлаж, МХАҮТ-тай хамтран сонгож болох юм. Хэлэлцүүлгийн бичлэгийг *ᠶᠡᠭᠡᠳᠡᠳᠡᠭᠡ ᠴᠠᠶᠠᠭ* Цувралаар дамжуулан мөн *ᠶᠡᠭᠡᠳᠡᠳᠡᠭᠡ ᠴᠠᠶᠠᠭ*, СЯ, МХАҮТ-ын вэб сайтад байрлуулан олон нийтэд хүргэж болно.

**4. Нээлттэй Засаг вэб сайтаас ивээн тэтгэн, татварын шинэтгэлийн талаар онлайн ярилцлага зохион байгуулах**

Хариуцагч: Азийн Сан/ЭЗБШӨЧ Төсөл  
Хамтран оролцогч: Ерөнхий Сайдын Ажлын Алба, ҮХЯ, СЯ  
Хугацаа: 5 дугаар сар

Татварын шинэтгэлийн асуудалтай холбоотой ЗГ-ын холбогдох удирдлагауудын онлайн цуврал ярилцлагыг *ᠶᠡᠭᠡᠳᠡᠳᠡᠭᠡ ᠴᠠᠶᠠᠭ* вэб сайтаас тусгай хувиарийн дагуу зохион байгуулна. Ярилцлага чөлөөтэй сэдвээр явагдах хэдий ч зохион байгуулагчид татвартай холбоотой асуултуудыг зориуд зарлаж ярилцлагыг татварын шинэтгэлийн асуудалд чиглүүлнэ. ҮХЯ, СЯ, ҮТЕГ-ын дарга ноён Л.Зориг нар энэхүү ярилцлагад оролцох болно. Ярилцлагын бичлэгийг *ᠶᠡᠭᠡᠳᠡᠳᠡᠭᠡ ᠴᠠᠶᠠᠭ* Цувралаар дамжуулан хүргэгдэх бөгөөд *ᠶᠡᠭᠡᠳᠡᠳᠡᠭᠡ ᠴᠠᠶᠠᠭ* болон СЯ-ны вэб сайтад байрлуулна.

**5. Татварын шинэтгэлийн талаар Нээлттэй Нийгэм Форумын телевизийн нэвтрүүлэг бэлтгэж явуулах**

Хариуцагч: Нээлттэй Нийгэм Форум  
Хамтран оролцогч: ЭЗБШӨЧ төсөл  
Хугацаа: 5 дугаар сар

Монголын үндэсний телевизийн үзэгчдийн сонирхлыг татаж буй нэвтрүүлгүүдийн нэг болон уг нэвтрүүлгээр татварын шинэтгэлийн асуудлаар хэлэлцүүлэг явуулж болох юм. Хөтлөгч иргэдийг зочдоос шууд асуулт асуухыг уриална. ЭЗБШӨЧ Төслөөс татварын шинэтгэлтэй холбоотой асуудлаар ерөнхий мэдээллийг бэлтгэж, тавих асуултуудыг санал болгож болох ба татварын шинэтгэлийн асуудалд хамааралтай хүмүүсийг нэвтрүүлгийн зочноор оролцуулна. Нэвтрүүлгийн бичлэгийг *ᠶᠡᠭᠡᠳᠡᠳᠡᠭᠡ ᠶᠡᠭᠡᠳᠡᠳᠡᠭᠡ ᠣᠶᠢᠳᠡᠳᠡᠶᠡ* вэб сайтад байрлуулах.

**6. ЗГ-ын хэвлэл мэдээллийн албаны ажилтнуудад мэдээлэл харилцаа асуудлыг хэрхэн зохицуулах талаар дэмжлэг туслалцаа үзүүлэх**

Хариуцагч: Азийн Сан/ЭЗБШӨЧ Төсөл  
Хамтран оролцогч: Ерөнхий Сайдын Хэвлэл Мэдээллийн Алба  
Хугацаа: Татварын багц хуулийг олон нийтэд танилцуулахаас өмнө, хойно

Азийн Сан/ЭЗБШӨЧ Төслөөс татварын шинэтгэлийн талаарх мэдээ мэдээлэл, ярилцлагын гол сэдвүүдийг яамдын хэвлэлийн төлөөлөгчдөд өгч

дэмжлэг туслалцаа үзүүлэх, чиглүүлэх. Хэвлэлийн төлөөлөгч нарт хэвлэлийнхний асуулганд хариулахад тусламж болгон Асуулт, Хариултын гарын авлага бэлтгэж өгөх боломжтой. Татварын хуулийг батласны дараа олон нийтэд танилцуулах зорилгоор хэвлэлийн бага хурал төлөвлөж, зохион байгуулах чиглэлийг гаргах.

#### **7. Нээлттэй Засаг вэб сайтад татварын шинэтгэлийн хуулийн төслийг байрлуулах**

Хариуцагч: Азийн сан/ЭЗБШӨЧ төсөл  
Хамтран оролцогч: Ерөнхий Сайдын Ажлын Алба  
Хугацаа: Татварын багц хуулийн тухай олон нийтэд мэдээлсэний дараа МУЗГ-ын татварын шинэтгэлийн хуулийн төслийг олон нийтэд мэдээлсэний дараа *Í үүёòòýé Çàñàà* вэб сайтад байрлуулж олон нийтэд санал бодлоо илэрхийлэх боломж олгох. Үүний зэрэгцээ хуулийг вэб сайтын нүүр хуудаст байрлуулж, сонинд нийтлэх. Хуулийн төслийн бүрэн эхийг *Í үүёòòýé Çàñàà* вэб сайтын Цувралаар сонирхогч талуудад хүргэнэ.

#### **8. Нээлттэй Нийгэм Форумын вэб сайтад Татварын шинэтгэлийн хуулийн төслийг байрлуулах**

Хариуцагч: Нээлттэй Нийгэм Форум  
Хамтран оролцогч: -  
Хугацаа: Татварын шинэтгэлийн багц хуулийг олон нийтэд танилцуулсны дараа

МУЗГ-ын татварын шинэтгэлийн хуулийн төслийг олон нийтэд мэдээлсэний дараа *Í үүёòòýé Í ёёäýì Òìðòì ùí* вэб сайтад байрлуулж олон нийтэд санал бодлоо илэрхийлэх боломж олгох. Татварын шинэтгэлийн талаар тусгай хуудас нээн ажиллуулж гарсан саналуудыг нэмж оруулан шинэчилж байх

#### **9. Татварын шинэтгэлийн талаар сэтгүүлчдэд зориулсан дугуй ширээний уулзалтыг зохион байгуулах**

Хариуцагч: ЭЗБШӨЧ Төслийн мэргэжилтэнүүд  
Хамтран оролцогч: Ерөнхий Сайд, СЯ-ны хэвлэлийн алба  
Хугацаа: Татварын шинэтгэлийн багц хуулийг олон нийтэд танилцуулсны дараа

Туршлагатай сэтгүүлчдийг үнэн зөв мэдээ, мэдээллийг уншигчдад хүргүүлэх зорилгоор тэдэнд татварын шинэтгэлийн багц хууль болон хуулийн төслийн эдийн засгийн үндэслэлийн талаар ойлголт өгөх. Сэтгүүлчид асуулт асуух боломжтой боловч тусгай зөвшөөрөл өгөөгүй тохиолдолд ерөнхий асуулт тавина.

#### **10. Хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлах**

Хариуцагч: Азийн Сан/ЭЗБШӨЧ Төсөл  
Хамтран оролцогч: Ерөнхий Сайдын болон СЯ-ны хэвлэлийн алба  
Хугацаа: Татварын шинэтгэлийн багц хуулийг олон нийтэд танилцуулсны дараа

Азийн Сан/ЭЗБШӨЧ Төслөөс Ерөнхий Сайд болон СЯ-ны хэвлэлийн төлөөлөгч нарт сонирхогч гол талуудаас татварын хөнгөлөлтийн талаар ярилцлага өгөх нэмэлт боломжийг судлан үзэж ярилцлага зохион байгуулах ажилд туслалцаа үзүүлнэ. Үүнээс гадна татварын шинэтгэлийн асуудлаар сэтгүүлчийн асуудал дэвшүүлсэн нийтлэлийг гол оролцогч талуудад танилцуулж зөвшөөрөл авч нийтлүүлнэ.

## **B2. Татвар болон төсвийн талаар сургалт**

### **1. ЗГ-ын гишүүд болоод УИХ-ын гишүүдэд татвар болон төсвийн талаар сургалт семинар зохион байгуулах**

Хариуцагч: Азийн Сан/ЭЗБШӨЧ Төслийн мэргэжилтнүүд  
Хамтран оролцогч: УИХ-ын Тамгын Газар  
Хугацаа: Сар бүр (УИХ-ын хуралдааны үеэр)

ЭЗБШӨЧ Төслийн мэргэжилтнүүд ЗГ-ын гишүүд, УИХ-ын гишүүдэд ардчилсан нийгэмд татварын систем болон засгийн газрын төсөв хэрхэн зохицуулагддаг талаарх эдийн засгийн мэдлэг олгох цуврал сургалт семинарыг сар бүр зохион байгуулах. Ингэснээр ЗГ-ын гишүүд болон ЭЗБШӨЧ Төслийн татварын мэргэжилтнүүдийн хооронд нээлттэй хэлэлцүүлэг хийх боломж гарах юм.

### **2. Бизнес эрхлэгчдэд зориулсан татвар болон төсвийн талаарх сургалт семинар**

Хариуцагч: Азийн Сан/ЭЗБШӨЧ Төслийн мэргэжилтнүүд  
Хамтран оролцогч: ХАМБЗ, МҮХАҮТ, СЯ-ны хэвлэлийн алба  
Хугацаа: Сар бүр

ЭЗБШӨЧ Төслийн мэргэжилтнүүд ардчилсан нийгэмд татварын систем болон засгийн газрын төсөв хэрхэн зохицуулагддаг талаарх эдийн засгийн мэдлэг олгох цуврал сургалт семинарыг бизнес эрхлэгчдэд зориулан сар бүр зохион байгуулах. Оролцогчдын дунд судалгааг тогтмол явуулснаар татвартай холбогдолтой асуудал болон татварын шинэтгэлийн зохицуулалтын арга хэмжээний нөлөөллийн талаар зөв ойлголтыг өгөх болно.

### **3. Хөдөөгийн бизнес эрхлэгчдэд зориулсан татвар, төсвийн талаарх сургалт семинар**

Хариуцагч: Азийн Сан/ЭЗБШӨЧ Төслийн мэргэжилтнүүд  
Хамтран оролцогч: Гэр санаачлага, СЯ-ны хэвлэлийн алба, ҮХЯ  
Хугацаа: 2 сард нэг удаа

ЭЗБШӨЧ Төслийн мэргэжилтнүүд ардчилсан нийгэмд татварын систем болон засгийн газрын төсөв хэрхэн зохицуулагддаг талаар эдийн засгийн мэдлэг олгох сургалт семинарыг хөдөөгийн бизнес эрхлэгчдэд зориулан хоёр сард нэг удаа зохион байгуулах. Оролцогчдын дунд судалгааг тогтмол явуулснаар татвартай холбогдолтой асуудал болон татварын шинэтгэлийн зохицуулалтын арга хэмжээний нөлөөллийн талаар зөв ойлголтыг өгөх болно.

### **4. Сэтгүүлчдэд зориулсан татвар, төсвийн талаарх сургалт семинар**

Гүйцэтгэгч: Азийн сан/ ЭЗБШӨЧ Төслийн мэргэжилтнүүд  
Хамтран оролцогч: Ерөнхий Сайдын болон СЯ-ны хэвлэлийн албад  
Хугацаа: Сар бүр

ЭЗБШӨЧ Төслийн шинжээчид ардчилсан нийгэмд татварын систем болон засгийн газрын төсөв хэрхэн зохицуулагддаг талаарх эдийн засгийн мэдлэг олгох сургалт семинарыг эдийн засгийн болоод бизнесийн талаар мэргэшсэн сэтгүүлчдийн дунд сар бүр зохион байгуулах. Иймэрхүү сургалтыг зохион байгуулснаар Засгийн газрын хэвлэлийн албад сэтгүүлчидтэй хамтран ажиллах нөхцлийг бүрдүүлнэ.

### **5. Татвар, төсвийн суурь мэдлэгийн талаарх танилцуулга/ сонин**

Хариуцагч: Азийн Сан/ ЭЗБШӨЧ Төслийн мэргэжилтнүүд

Хамтран оролцогч: СЯ-ны хэвлэлийн алба  
Хугацаа: Улирал тутам

Мэдээллийн агуулгатай иймэрхүү хэвлэмэл нь ардчилсан нийгэмд татварын систем болон засгийн газрын төсөв хэрхэн зохицуулагддаг талаарх эдийн засгийн суурь мэдлэг олгохоос гадна засгийн газрын орлогын эх үүсвэр, нийгмийн хэрэгцээнд зориулсан бараа бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээнд засгийн газраас гаргаж буй зардал, татварын гүйцэтгэж буй үүрэг, салбаруудаас орж буй татварын орлогын хувь хэмжээ, ирээдүйн орлогын талаарх Монголын төлөвлөгөө зэргийг багтаана. Мэдээллийг дээд дурьдагдсан ЭЗБШӨЧ Төслөөс зохион байгуулах сургалт семинар, доор дурьдагдах хэвлэл мэдээллийн хөтөлбөрөөс авна. Хэвлэмэлийг тараах боломжит сувгууд: ГЭР санаачлага, ХААН банкны салбаруудаар дамжуулан хөдөөгийн бизнес эрхлэгчдэд, МХАҮТ болон бизнесийн холбоодоор дамжуулан хот суурин газруудын бизнес эрхлэгчдэд, татварын алба, СЯ-ны хүлээлгийн танхим, Нээлттэй Нийгэм байгууллагын мэдээллийн төвөөр үнэгүй тараах, мөн Нээлттэй Засаг Цуврал нийтлэх.

## **6. СЯ-наас татвар ба төсвийн эдийн засгийн талаар телевизийн нэвтрүүлэг бэлтгэх**

Хариуцагч: Гэрээгээр  
Хамтран оролцогч: Азийн сан/ЭЗБШӨЧ, СЯ-ны хэвлэл мэдээллийн алба  
Хугацаа: 7 хоног тутам

Телевизийн энэхүү шинэ хөтөлбөр нь татвар ба төсвийн эдийн засгийн тухай мэдлэгийг хөгжилтэй, уян хатан, амьдралд ойр байдлаар олон нийгэд хүргэхийн тулд сонирхолтой жүжигчилсэн тоглолтыг мэдлэг боловсрол олгох хэлбэртэй хослуулна. ЭЗБШӨЧ төсөл нь орон нутгийн аж ахуйн нэгж буюу ТББ-тай нэвтрүүлгийг бэлтгэх, жүжиглэх хүмүүсийг сонгон шалгаруулах, агуулгыг гаргах талаар гэрээ байгуулж ажиллах холбогдох эдийн засгийн асуудлаар заавар чиглэл өгнө. Сургалтын гарын авлага орон нутгийн хэвлэлд нийтлүүлж СЯ-ны цахим хуудсанд байрлуулах замаар эдийн засгийн боловсролын агуулгыг сайжруулна.

## **7. Засгийн газрын телевизийн мэдээллийн хөтөлбөр**

Хариуцагч: СЯ-ны хэвлэл мэдээллийн алба  
Хамтран оролцогч: Азийн Сан/ЭЗБШӨЧ Төсөл  
Хугацаа: Тодорхойгүй байгаа

Засгийн газрын албан ёсны мэдээллийн хөтөлбөрт урьд нь авч хэлэлцэж байсан татварын шинэчлэлтийн асуудлыг тусгасан бөгөөд татварын хөнгөлөлт, олж буй амжилт ололтын талаар цаг тухай бүрт нь мэдээнэ. ЭЗБШӨЧ Төсөл нь СЯ-ны хэвлэл мэдээллийн албаар дамжуулан ардчилсан нийгмийн татварын систем, засгийн газрын төсвийн тухай эдийн засгийн үзэл баримтлалын асуудлаар зохиогддог сар тутмын семинарын мэдээлэл, мөн татварын хөнгөлөлтийн талаар хийж буй судалгаа, олж буй ололт амжилтын талаар мэдээллийн хөтөлбөрт тусгаж мэдээнэ.

## **8. Татвар, төсвийн эдийн засгийн тухай радио нэвтрүүлэг**

Хариуцагч: Азийн сан/ЭЗБШӨЧ  
Хамтран оролцогч: ПАКТ, СЯ-ны хэвлэл мэдээллийн алба  
Хугацаа: Тогтсон хуваарийн дагуу

Хэд хэдэн радио нэвтрүүлгийн суваг ЭЗБШӨЧ Төслөөс гаргаж буй татвар, төсвийн талаарх мэдээллийг нэвтрүүлэх сонирхолтой байна. ПАКТ-ын олон улсын радио нэвтрүүлэг хөдөөгийн малчин, тариаланчдад мал маллагаа, бизнес эрхлэх арга барилын мэдээллийг радио жүжгийн

хэлбэрээр хүргэдэг. Сургалтын гарын авлага орон нутгийн хэвлэлд нийтлүүлэх замаар боловсролын агуулгыг сайжруулна. ЭЗБШӨЧ төсөл нь татвар, төсвийн эдийн засаг, мөн татварын хуулийг дагаж мөрдөхийн ач холбогдлын талаар гол мэдээллийг өгнө. СЯ Монголын радиогоор Сангийн Сайд, ҮТЕГ-ын даргыг оролцуулсан ярилцлага зохион байгуулахаар төлөвлөж байгаа бөгөөд хөтөлбөрт ярианы сэдэв, татвар, төсвийн талаар ярилцлагын гарын авлагыг тусгана.

## 9. Татварын хуулийн дагаж мөрдөх талаар олон нийтэд хүргэх зар

Хариуцагч: Азийн сан/ЭЗБШӨЧ Төсөл  
Хамтран оролцогч: Бизнесийн холбоод?  
Хугацаа: 3-5 дугаар нэвтрүүлсэн/5 сар гаруй хэвлэгдэж байгаа

Богино хугацаатай телевизийн сурталчилгаа, радио, сонины зарууд нь иргэдээс *ᠡᠳᠦᠭᠠᠵᠢᠭᠦᠨ ᠶ᠋ᠢᠨ ᠶ᠋ᠢᠨ* татвараа төлөхийг уриалж Монголын алдартай хүмүүсийг шог зургаар дүрсэлж анхаарлыг нь татдаг. Алдартнуудад улс төрийн нэр зүтгэлтэн, дуучин, сумо бөхчүүдийг оруулдаг. Олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр дээрх зарлал сурталчилгааг 5 сарын хугацаатай явуулах (төсвөөс хамааран) ба ХАМБЗ зэрэг иргэний хөгжлийг дэмждэг бизнесийн холбоод хэсэгчлэн санхүүжүүлж засгийн газрын телевиз, радиогоор үнэ төлбөргүй нэвтрүүлгийн цагаар нэвтрүүлнэ.

## 10. Цахим хуудасны мэдээллийн хуудас

Хариуцагч: Азийн Сан/ЭЗБШӨЧ Төсөл  
Хамтран оролцогч: Нээлттэй Нийгэм Форум, СЯ, МҮХАҮТ, бусад  
Хугацаа: Сар бүр шинэчлэх

Татвар, төсвийн талаарх семинар, товхимол/сонины мэдээллийг *ᠶ᠋ᠢᠨ ᠶ᠋ᠢᠨ* *ᠴᠠᠶᠠᠭᠠ*, Нээлттэй Нийгэм Форум, СЯ, МҮХАҮТ болон бусад цахим хуудсанд шинэчлэн байрлуулах цахим хуудасны мэдээлэл болгож ашиглана.

## 11. ГЭР Санаачлага төслөөс сар тутамд хэвлэн гаргадаг бичил бизнесийн сонинтой хамтран ажиллах

Гүйцэтгэгч: ГЭР санаачлага  
Хамтран оролцогч: Азийн Сан/ЭЗБШӨЧ Төсөл  
Хугацаа: Сар бүр

Дээр дурьдсан цахим хуудсанд ашигласан мэдээллийг бичил бизнес эрхлэгчдэд холбоотой татварын мэдээлэлтэй нийтлэл гаргахад ашиглаж СНФ-ийн бичил бизнесийн сонинд хэвлэнэ. Татварын тухай асуулт хариултын буланг бизнес эрхлэгчдийн харилцах суваг болгон ашиглана.

## 12. Хэвлэл мэдээллийн хэрэгсэл

Гүйцэтгэгч: Азийн Сан, ЭЗБШӨЧ Төсөл  
Хамтран оролцогч: Ерөнхий сайдын болон СЯ-ны хэвлэл мэдээллийн албад  
Хугацаа: Татварын багц хуулийг олон нийтэд танилцуулсны дараа

Азийн Сан ба ЭЗБШӨЧ Төсөл Ерөнхий Сайдын болон СЯ-ны хэвлэл мэдээллийн албадын санал хүсэлтэд хариу өгөх, гол оролцогч талуудаас мэдээлэл авах ярилцлага авах, татварын талаарх онцлог үйл явдлын талаар мэдээлэл олох боломжийг тодорхойлоход туслана. Түүнээс гадна цаг үеийн асуудлаар сэтгүүлчийн асуудал дэвшүүлсэн нийтлэлийн төсөл боловсруулж гол оролцогч талуудад танилцуулж дэмжлэг авна.

## Г. Мессеж дамжуулагч

Татварын хөнгөлөлтийн хуулийг батлах хүчин чармайлтын улс төрийн орчинд байгаа хэвлэлийн төлөөлөгчдийн хувьд эдгээр мэдээллийг хүргэх сонголт хийх нь энэхүү мэдээлэл харилцааны ажлын төлөвлөгөөг амжилтад хүргэхэд чухал ач холбогдолтой. Оролцогч талууд мэдээлэл дамжуулагчдыг найдвартай, нөлөөтэй гэж үздэг бөгөөд үнэн бодитой мэдээллийн эх сурвалж гэж хүндэтгэлтэй ханддаг.

Ерөнхий сайдын *Í úýèðòýé Çàñàà* цахим хуудас нь хуулийн төсөл болон татварын хөнгөлөлтийн эргэн тойронд өрнөж буй улс төрийн үйл явцыг харуулах албан ёсны харилцааны логик дамжуулагч юм. *Í úýèðòýé Çàñàà* гэдэг нэр нь найдвартай мэдээллийн эх сурвалж хэмээн хүлээн зөвшөөрөгдсөн брэнд юм. Үүнд цахим шуудан, цуврал, шууд ярилцлага багтдаг. ЭЗБШӨЧ Төсөл *Í úýèðòýé Çàñàà* вэб сайтын үйл ажиллагаа болон үйл ажиллагааны төлөвлөгөөг дэмжиж байх болно.

СЯ татварын бодлогын төлөвлөлтийг удирдаж байгаагийн хувьд татвар болон төсвийн талаарх боловсролын үйл ажиллагааг явуулах үндсэн байгууллага байх болно. Боловсролын үйл ажиллагаа гэдэгт телевизийн хөтөлбөрүүд, олон нийтийн зар сурталчилгаа, мэдээллийн танилцуулга, сэтгүүлчдийн сургалт семинар, яамны цахим хуудас болно. СЯ жил бүрийн 5 дугаар сарын 9-13-ны хооронд явагддаг татвар төлөгчдийн 7 хоногийг зохион байгуулдагийн хувьд өөрөө мэдээллийн эх сурвалж болох ба энэ жилийн хувьд сайн дураараа татвар төлөгчдийг урамшуулан дэмжсэн юм. Тус яамны хэвлэлийн алба ЭЗБШӨЧ Төсөлтэй хамтран татварын боловсролын үйл ажиллагааны хөтөлбөр гаргасан төдийгүй зарим ажлыг хамтран зохион байгууллаа.

Зарим бизнес эрхлэгчид гадаадын хандивлагчдыг найдвартай мэргэжлийн үнэн зөв мэдээлэл өгдөг эх сурвалж гэж үздэг. ЗГ-ын гишүүдэд татварын хөнгөлөлттэй холбоотой мэдээллийг хүргэхэд ЭЗБШӨЧ Төсөл дамжуулагчийн үүрэг гүйцэтгэж болно. Ингэснээр бидний авч хэлэлцэж байгаа асуудал улс төрийн маргаанаас гадуур тавигдах төдийгүй оролцогч талуудад нээлттэй байх болно. ЗГ болон бизнесийн төлөөлөгчидтэй хийх уулзалтыг *Í úýèðòýé Çàñàà* цахим хуудсаар дамжуулан зохион байгуулж болно.

Олон нийтийн зар сурталчилгааны хувьд санал болгосон телевиз, радио, сонины зарлал нь олон нийтийн анхаарлыг татах гэсэн зорилгыг агуулж байгаа бөгөөд тийм ч учраас олны танил хүмүүсийг оролцуулах шаардлага гарч байгаа юм. Сурталчилгаанд оролцуулж болох олны танил хүмүүсийн тоонд улс төрч, дуучин, сумо бөхчүүдийг оруулж болно. Үүнийг цаашид ажлын төлөвлөгөөнд авч үзнэ.

Энэхүү төлөвлөгөө нь Нээлттэй Нийгэм Форум, ПАКТ Интернейшнл зэрэг зарим ТББ, СНФ ГЭР санаачлага зэргийн хандивлагчдын төсөл, МҮХАҮТ зэрэг бизнесийн байгууллагуудын үйл ажиллагааг хянах юм. Эдгээр байгууллагууд нь татварын хөнгөлөлтийн сэдвийг өөрсдийн хөтөлбөр болон ажлын төлөвлөгөөнд оруулахыг зөвшөөрсөн.

## Д. Мэдээлэл харилцааны ажилд тохиолдох цаашдын бэрхшээл

Монголын татварын бүтцийг шинэчилнэ гэдэг нь ярвигтай, тасралтгүй үргэлжлэх үйл явц юм. Татварын хөнгөлөлтийн талаар гаргаж буй хүчин чармайлтын зорилго нь татварын тэнцвэргүй байдал, өрсөлдөөний талаар гарч буй гажуудлыг арилгахад чиглэсэн хэдий боловч татварын зохицуулалт,

татвар хураалт, татварын хуулийг дагаж мөрдөх талаар тохиолдож буй хүндрэл, төсвийн зарлагын ил тод байдлын асуудлыг авч үзээгүй байна. ЗГ гол оролцогч талуудтай улс төрийн харилцаа холбоогоо сайжруулахын тулд зарим нэг арга хэмжээ авах ёстойг ойлгох нь чухал бөгөөд зарим нэг асуудалд ЗГ хариулт өгөх боломжгүй байдаг гэдгийг тооцож үзэх хэрэгтэй. Энэ нь ардчилсан үйл явцын үнэн бодит байдал юм. Энэ тохиолдолд татвар төлөгчийн үүрэгтэй холбоотой асуудлуудыг татвар төлөгчийн эрхтэй тэнцэтгэж ойлгох ёстой. Татварын удирдлага, хураалтын хувьд ЭЗБШӨЧ Төслөөс татварын удирдлага, хураалтыг зохицуулах төлсийг боловсруулахад Үндэсний татварын газарт туслалцаа үзүүлсэн юм. МУЗГ-ын бий болгосон сувгуудаар дамжуулан ҮТЕГ олон улсын агентлагуудад санхүүжилт олгох саналыг тавьж болно.

Гэхдээ энэ үйл ажиллагааны хувьд мэдээлэл харилцааны ажил чухал юм. Татварын газар хуулийн дагуу удирдлагын арга туршлагаа сайжруулах ёстойгоос гадна мэдээллийг ард иргэдэд хүргэх олон сувгуудыг тодорхойлох ёстой. Татвар төлөгчид татвар тооцох аргачлалыг мэддэг байхын зэрэгцээ мөн эргэлзээтэй зардлыг мэддэг байх шаардлагатай юм. Олон нийтэд үйлчилдэг журмууд нь татвар хураалтыг сайжруулах, хэрэгжилтийг гүйцэтгэх шаардлага гаргаж ирдэг ба ингэснээр бизнес эрхлэгчид татварын зардлаа төлөвлөх боломжтой болдог.

ЗГ-ын төсвийн зарцуулалтыг нээлттэй байлгахын тулд татварын орлогыг хэрхэн зарцуулсан талаарх мэдээллийг хэвлэх нь маш чухал юм. Татварын төлөгчид тэдний төлсөн татвар юунд зарцуулагдагийг мэдэх тусам татвартай холбоотой тэдний гомдол, санал бодлын тоо нэмэгддэг. Мөн төсөв бүрдүүлэх талаар мэдлэг олгох, ЗГ-аас төсвийг хэрхэн зарцуулдаг талаар болон зарцуулалт хийх хувилбаруудын бодлогыг олон нийтэд тайлбарлаж өгөх нь чухал юм.

**ХАВСРАЛТ А: ЗОХИОН БАЙГУУЛСАН УУЛЗАЛТУУД**



## **ХАВСРАЛТ А: ЗОХИОН БАЙГУУЛСАН УУЛЗАЛТУУД**

---

### **Монгол улсын Засгийн газар**

#### **Ерөнхий сайдын алба**

- Ноён Ц.Элбэгдорж Ерөнхий сайд
- Ноён Д.Болдхуяг Ерөнхий сайдын хэвлэлийн төлөөлөгч, Хэвлэл Мэдээллийн албаны дарга
- Засгийн газрын яамдуудын хэвлэл мэдээллийн төлөөлөгчид

#### **СЯ**

- Ноён Н.Алтанхуяг Сангийн сайд
- Ноён Л.Зориг Үндэсний татварын газрын дарга
- Хатагтай Д. Баасанхүү Бодлого Зохицуулалтын газрын дарга, хэвлэл мэдээллийн албаны дарга
- Хатагтай С.Цэцэг-Өлзий хэвлэлийн төлөөлөгч

#### **ҮХЯ**

- Ноён Д.Зоригт, Бодлого Зохицуулалт, Стратеги төлөвлөлтийн газрын дарга

### **Монгол Улсын Их Хурал**

- Ноён Н.Энхбаяр УИХ-ын дарга, МАХН-ын дарга
- Ноён Н.Энхболд УИХ-ын гишүүн, УИХ дахь МАХН-ын бүлгийн дарга
- Хатагтай С.Оюун УИХ-ын гишүүн, ИЗН-ын тэргүүн
- Хатагтай Надин Крайсбергер УИХ-ын гишүүн С.Оюуны зөвлөх

#### **Татварын хуулийн ажлын хэсэг**

- Ноён Р.Бадамдамдин УИХ-ын гишүүн, Төсвийн байнгын хорооны дарга
- Ноён Н.Энхболд, УИХ-ын гишүүн
- Ноён Р.Амаржаргал УИХ-ын гишүүн
- Ноён Ц.Сүхбаатар УИХ-ын гишүүн

#### **Монголын бизнесийн бүлэг**

- Хойд Америк Монголын бизнесийн зөвлөл Ноён Питер Морроу, ХААН банкны ТУЗ-ын дарга
- МҮХАҮТ - ноён С.Дэмбэрэл, ерөнхийлөгч
- ХААН банк - ноён Бен Тёрнбалл, ахлах ажилтан
- Номин Холдингс хатагтай Ш.Нурмаа, ерөнхий менежер
- MCS групп /Делл, Пепси болон бусад/ - ноён А.Ганхуяг, Санхүү хариуцсан дэд захирал, ноён А.Энхтүвшин, Стратеги, төлөвлөлтийн дэд захирал
- Үйлдвэр худалдааны сүлжээ ХХК хатагтай А.Зумаа, гүйцэтгэх захирал

#### **Монголын Төрийн бус байгууллагууд /ТББ/**

- Монголын Нээлттэй Нийгэм Форум хатагтай Б.Мөнхсоёл, менежер

- Сант Марал Сан ноён Л.Сумати, захирал, Хойд Америк Монголын бизнесийн зөвлөлийн гишүүн
- Хэвлэл мэдээлэл стратеги Монголын Мэдээллийн сүлжээ ноён Б.Бат-Оргил, гүйцэтгэх захирал
- РАСТ Монгол ерөнхий редактор Д.Ганхуяг, техникийн ахлах зөвлөх ноён Стеван Бакст Хөгжлийн мэдээлэл

Олон улсын хандивлагч байгууллагууд

- ОУВС-гийн суурин төлөөлөгч хатагтай Дон Рем
- Азийн Сангийн Монгол дахь төлөөлөгч Лейтон Крофт, хөтөлбөрийн ажилтан Бадамдаш
- СНФ Гэр санаачлага орон нутгийн захирал хатагтай Маргарет Херро
- ОУБНХ-ын захирал ноён Жон Пөпсел

ЭЗБШӨЧ Төслийн баг

- Ноён Фернандо Бертоли, Төслийн удирдагч
- Ноён Януш Ширмер, Эдийн засгийн ахлах зөвлөх
- Ноён Ларри Женсен, Нягтлан бодох бүртгэл, татварын зөвлөх
- Хатагтай Жо Бет Мертенс, Монголын татварын системийн стандартыг тогтоох зөвлөх

АНУ-ын ОУХА

- Ноён Леон С. Васкин, Суурин Төлөөлөгч

**ХАВСРАЛТ Б: ТАТВАРЫН ШИНЭЧЛЭЛИЙН ЯРИЛЦЛАГЫН СЭДВҮҮД**



## ХАВСРАЛТ Б: ТАТВАРЫН ШИНЭЧЛЭЛТИЙН ЯРИЛЦЛАГЫН СЭДВҮҮД

(Ерөнхий сайдын хэрэгцээнд зориулав)

- Бид Засгийн газраас 2004 онд боловсруулсан дөрвөн жилийн ажлын төлөвлөгөөг эхний жилд хэрэгжүүлж байна. Бидний боловсруулсан төлөвлөгөөнд тусгагдсан зорилго ба зорилтуудыг хангах нь Засгийн газар болоод миний хувьд нэн чухал үүрэг болж байна.
- Ажлын төлөвлөгөөнд “макро эдийн засгийн тогтвортой хөгжлийг хангаж бизнесийн таатай орчин бий болгох, дэд бүтцийн хөгжилд хөрөнгө оруулснаар шинээр 145,000-аас багагүй ажлын байр нэмэгдүүлнэ” гэсэн заалт оруулсан.
- Мөн “татвар болон ажилчдаас авдаг татаасын дарамтыг буруулж, ажлын байр нэмэгдүүлэх боломжтой аж ахуйн нэгжүүдийг дэмжих, Монголын өрхийн амьжиргааны түвшин болон орлогыг нарийвчлан тооцсон татварын уян хатан бодлого хэрэгжүүлнэ” гэсэн заалт оруулсан.
- Засгийн газар татварын шинэчлэлийн бодлогыг Монголын ард түмэнд хүргэх тал дээр багагүй амжилт гаргасан.
- СЯ бизнесийн байгууллага, ард түмэнд тохиолдож татварын дарамтыг бууруулах санал боловсруулахаар ажиллаж байгаа бөгөөд мөн Монголын нөхцөлд зохицсон орчныг бий болгохыг зорьж байна
- ҮХЯ жижиг дунд бизнес эрхлэгчдийн санал хүсэлтийг хүлээн авахын тулд үндэсний хэмжээнд зөвлөлгөөн зохион байгуулж татварын шинэчлэлийн асуудал дээр ажиллаж байна.
- Энэхүү үйл ажиллагааны үр дүнд татварын шинэчлэл нь дараахь шинж чанартай байх ёстой гэсэн тохиролцоонд хүрээд байна. Үүнд:
  - Монгол ашиглагдаж байгаа татварын ангиллыг нэмэгдүүлэх
  - Монголын өрсөлдөөний чадавхийг дээшлүүлэх
  - Ажлын байр шинээр бий болгохыг дэмжих үүднээс бизнес эрхлэгчдийн татварын дарамтыг бууруулах
  - Гадаадын болон дотоодын хөрөнгө оруулагчдын татварын ялгаврыг арилгах
  - Татварын зохицуулалт хийх журмыг хялбарчлах
- Татварын шинэчлэлийн төслийн эцсийн хувилбар нь хувийн салбарын өсөлтийг дэмжиж, ажлын байрыг шинээр нэмэгдүүлэх боломж олгох ба татварын шударга, ил тод системийг бий болгосноор Монголын бизнес эрхлэгчид болон хөдөлмөр эрхлэгчдийг дэмжинэ.
- Бидний хийх татварын шинэчлэл нь илүү шударга, илүү хялбар татварын орчныг бүрдүүлэхийг зорих бөгөөд ингэснээр Монгол улс далд эдийн засгийн сүлжээг устгаж, татвараа үнэнч шударгаар төлөх болох төдийгүй НББ-ийн хуурамч бичилт хийж ашгаа нуухаас татгалзах болно.
- Дээр дурьдсан зорилтуудыг бид бүгд хүлээн зөвшөөрсөн юм. Цаашид би зөвлөлгөөний үйл явцыг хурдасгаж хуулийн төслийг боловсруулахад УИХ-ын дарга Н.Энхбаяр болон УИХ-тай хамтран ажиллана гэж найдаж байна.

- Нэгэнт бид зөвшилцөж чадсан учир хуулийн төслүүдийг Нээлттэй Засаг хөтөлбөрийн цахим хуудсанд байрлуулах болно. Ингэснээр Монголын иргэд хуулийн төслүүдтэй танилцаж санал бодлоо илэрхийлэх боломжтой болох төдийгүй УИХ зөвлөлдөх уулзалтуудаа үргэлжлүүлэх болно гэж бодож байна
- Татварын ил тод, нээлттэй системээр дамжуулан манай улсын эдийн засаг өсч Монголын иргэд хүсэн хүлээж буй сайхан амьдралаараа амьдрах болно.